Шилжилт хөдөлгөөн: Шинэ (Зүүн Берлинийг оролцуулан) болон хуучин муж улсуудын хооронд шилжилт хөдөлгөөн мөн л үргэлжилсээр байна. Эцсийн бус мэдээгээр 2004 онд шинэ муж улсуудаас хуучин муж улсууд руу шилжин суурьшигсдын тоо 146.352 (2003 онд 155.385)-д хүрсэн бол харин хуучин муж улсуудаас шинэ муж улсууд руу шилжин суурьшигсдын тоо 94.577 (97.035)-д хүрч, ийнхүү 2004 онд шилжин суурьшигсдын тооны зөрүү 51.775-д хүрсэн нь шинэ муж улсуудын хувьд таатай бус байв.

Харъяалал: 2003 онд (өөр шинэ тоо баримт хараахан гараагүй байна) Германы харъяат болсон гадаад хүмүүсийн тоо дахин буурсан бөгөөд 136.851 (2002 онд 154.547) хүн Германы харъяат болсон нь түрүү жилийнхээс 17.696 хүнээр буюу 11,45%-иар бага байна. Улсын харъяатын эрхийг шинээр олгох болсон 2000 онд 186.688 хүн Германы харъяат болсноор, оргилдоо хүрсэн бөгөөд үүнээс хойш энэ тоо байнга буурсаар байна. 2003 онд Германы харъяат болсон 136.851 гадаад иргэдийн 56.240 (64.631) нь турк, 9431 (13.021) нь иран, 5103 (8375) нь серб, монтенегр (хуучин Югославын), 4948 (4749) нь афган, 4118 (3800) нь марокко, 3887 (3655) нь украин, 3010 (2027) нь казах, 2998 (1721) нь ирак хүмүүс байв.

Гадагшаа гарсан германчууд: Гадагшаа гарсан германчууд

буцаж эх орондоо шилжин суурьших явдал хэдэн жилийн тэртээгээс тасралтгүй явагдаж буй бөгөөд 2004 онд ч мөн адил үргэлжилж, 59.093 германчууд болон түүний хамаатан садны хүмүүс Германд буцаж суурьшсан ба энэ тоо 2003 онд 72.885 байв. 2004 онд германчууд голчлон ОХУ-аас нутагтаа буцаж ирсэн байв.

Гадаадын хүмүүс: 2004 оны сүүлчээр ХБНГУ-д 6.717.115 гадаадын иргэд амьдарч байсан нь урьд жилийн мөн үеийнхтэй харьцуулахад 8%-иар (2003 онд 7.334.765) буурсан байна. Холбооны Статистикийн Албаны мэдээлснээр гадаад иргэдийн тоо ийнхүү буурсан нь гадаад иргэдийн гол бүртгэлийг цэгцэлсэнээс үүдэлтэй тул үүнийг урьд жилийн тоотой харьцуулах боломжгүй юм. 2004 оны эцэс гэхэд тэдний Германд амьдарсан дундаж хугацаа 16,1 жил, гуравны нэг нь 20 гаруй жил, гуравны хоёр нь 8 ба түүнээс жил Германд амьдарч, Германы иргэншлийг авахад шаардлагатай хугацааг хэдийнээ өнгөрүүлсэн байна. Гэвч энэ боломжийг гадаадын хүмүүс ашиглах явдал нь Европын Холбоо өргөжсөний улмаас улам бүр багасч байна. Герман дахь нийт гадаад иргэдийн 26,3% буюу 1,764 сая туркууд байгаа нь хамгийн олон тоотой гадны иргэд болно. 8,2% нь буюу 548.194 хүн Италиас, 7,6% нь буюу 507.328 хүн Серб, Монтенегро-гоос тус тус ирсэн байна. Бусад улсууд: Грек 315.989 (4,7%), Польш 292.109 (4,3%), Хорват 229.172 (3,41%), ОХУ 178.616 (2,66%), Босни-Герцоговин 155.973 (2,32%), Украин 128.110 (1,91%), Португаль 116.730 (1,74%), Нидерланд 114.087 (1,70%).

Орогнол хүсэгчид: 2004 онд орогнол хүссэн өргөдлийн тоо Германд мөн Европын Холбооны дунджаас улам буурч, доод цэгтээ хүрсэн байна. Нийт 35.607 хүн орогнол хүссэн нь урьд жилийнхээс 29,6%-иар (2003 онд 50.563) буурч, 1984 оны төвшинд хүрсэн байна. Орогнох зөвшөөрөл олгосон хувь хэмжээ 2004 онд 1,5% (2003: 1,6%) болж буурчээ. 61.961 (93.885) өргөдлийг шийдвэрлэсэнээс 960 (1534) хүнд орогнох эрхийг олгосон байна. 1107 (1602) хүнд нутгаасаа дайжин гарахад нь хамгаалалт үзүүлжээ. 2004 онд орогнол хүсэгчдийн 4148 (6301) нь Турк, 3855 (4909) нь Серб, Монтенегро, 2757 (3383) нь ОХУ-аас, 1668 (2096) нь Вьетнам, 1369 (2049) нь Иран, 1363 (1291) нь Азербайджан, 1293 (3850) нь Ирак,

1186 (2387) нь Хятадын иргэн байв.

Дүрвэгсэд: 2000 оноос хойш 1,1 сая дүрвэгсэд (Женевын Конвенцийн дагуу авч үзвэл дүрвэгсдийн статустай болон статусгүй) ХБНГУ-д байрлаж байна. Үүнээс:

- 92.000 нь орогнол эдлэгсэд ба гадаад улс оронд хүлээн зөвшөөрөгдсөн дүрвэгсэд,
- 120.000 нь орогнол эдлэгсдийн гэр бүл,
- 70.000 нь Конвенцийн хүрээнд дүрвэгсэд,
- 5.500 нь хүмүүнлэгийн тусламж болгон гамшиг тохиолдсон нутгаас тогтоосон тоо хэмжээний дагуу хүлээн авсан дүрвэгсэд,
- хуучин ЗХУ-аас цагаачлагч 200.000 еврэй,
- 7.500 нь харъяалалгүй хүмүүс,
- 86.000 нь орогнол эрэгсэд,
- 370.000 нь Дефакто-дүрвэгсэд байв. (2004 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар)

Гэмт хэрэг

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн статистикийн дагуу 2004 онд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо урьд жилийнхтэй харьцуулахад 0,9%-иар өсч, 6,663 (2003 онд 6.572) сая-д хүрсэн байна. Холбооны нийт нутгийн хэмжээгээр 100.000 хүн тутамд 8037 гэмт хэрэг оногдож байна.

Гэмт хэргийн дотор хамгийн их хувийг эзэлж буй хулгайн гэмт хэргээр 2004 онд 2,961 сая үйлдэл бүртгэгдэж, 2,3%-иар буурсан байна. Үүнд дэлгүүр ухсан 4.509.417 гэмт хэрэг гарч, 4,7%-иар буурсан, механикжсан тээврийн хэрэгслээс хулгай хийсэн 439.654 (-4,2%) гэмт хэрэг, унадаг дугуй хулгайлсан 412.097 (-5,7%) гэмт хэрэг тус тус гарсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргүүдийн дотор хүний эрх чөлөөнд халдсан гэмт хэрэг (+5,25%) үүнд дээрэмдсэн, дээрэмдэхээр сүрдүүлсэн, хүний биед гэмтэл учруулсан, барьцаалсан гэмт хэргүүд өсч, үүнд 718.053 үйлдэл бүртгэгджээ. Залилангийн хэрэг бүртгэгдсэн гэмт хэргийн дотор цаашлаад томоохон байрыг эзэлж байна. Үүнд 941.859 үйлдэл бүртгэгдэж, 7,5%-иар өссөн бөгөөд чингэхдээ интернетийг гэмт үйлдлийн хэрэгсэл болгон илүүтэй ашиглажээ. 2004 онд мөн мансууруулах бодисын 283.708 гэмт хэрэг

(+11%) гарсан байна. Энэ төрлийн гэмт хэрэг ийнхүү нэмэгдсэн нь замын хөдөлгөөнд оролцохдоо мансууруулах бодис хэрэглэсэн төрхийг илүү эрчимтэй шалгах болсонтой зарим талаар холбоотой юм. Бэлгийн мөлжлөгийн чанартай нийт 57.306 гэмт хэрэг (+4,9%) бүртгэгдсэнээс хүүхдийг садар самуунд уруу татсан 15.255 (-1,1%) гэмт хэрэг, хүчин, секс халдлагын 8831 гэмт хэрэг (+0,7%) тус тус гарсан байна.

Герман: Гэмт хэргийн бүрэлдэхүүн 2004

Гэмт хэргийн төрөл	%-иар
Хулгайн хөнгөн гэмт хэрэг	22,9
Хулгайн ноцтой хэрэг	21,8
Бусад гэмт хэрэг	17,2
Эд хөрөнгийн хохирол учруулсан гэмт хэрэг	10,9
Залилангийн гэмт хэрэг	14,2
Хүний биед гэмтэл учруулсан гэмт хэрэг	7,5
Мансууруулах бодисын гэмт хэрэг	4,3
Эдийн засгийн гэмт хэрэг	1,2

Боловсрол

Ерөнхий боловсролын дунд сургууль. 2003/2004 оны хичээлийн жилд 9,727 (2002/2003 оны хичээлийн жилд 9,780) сая сурагчид Ерөнхий боловсролын сургуульд сурсан. Үүнээс сургуулийн өмнөх сургалтанд 54 (55) мянган сурагч, бага сургуульд 3,147 (3,144) сая сурагч, дунд сургуульд 1,092 (1,111) сая сурагч, хэд хэдэн сонгон хичээл бүхий сургуулийн төрлүүдэд 428 (438) мянган сурагч, ахлах сургуульд 1,297 (1,283) сая сурагч, гимназид 2,316 (2,297) сая сурагч, нэгдсэн цогцолбор сургуульд 545 (547) мянган сурагч, тусгай сургуульд 429 (429) мянган сурагч хамрагдаж байна. 2003/2004 оны хичээлийн жилийн эхний улиралд 843,8 (803,8) мянган хүүхэд сургуульд орсон. 2003/2004 оны хичээлийн жил дуусахад дээд сургууль болон мэргэжлийн дээд сургуульд элсэн суралцах боломжийг хангасан гимнази төгсөгчдийн тоо урьд жилийнхтэй харьцуулахад 4,5%-иар өсч, 385,7 (369,0) мянгад хүрсэн байна. Гимнази төгсөгчдийн тоо 1995 оноос хойш 25%-иар

өсөөд байна. Сургуулийн багш нарын (бүтэн болон хагас өдрөөр ажилладаг багш нар, цагийн багш нарыг оролцуулан) тоо 2003/2004 оны хичээлийн жилд 744.157 (743.547)-д хүрч, үүнээс 210.657 (212.219) нь бага сургуульд, 83.148 (82.132) нь дунд сургуульд, 36.751 (35.412) нь хэд хэдэн сонгон хичээл бүхий сургуульд, 82.323 (81.215) нь ахлах сургуульд, 173.852 (171.791) нь гимназид, 43.314 (43.481) нь нэгдсэн цогцолбор сургуульд, 76.919 (75.979) нь тусгай сургуульд тус тус багшилж байв.

Дээд сургууль: 2004/2005 оны (бүрэн бус мэдээгээр) өвлийн семестерт суралцсан оюутны тоог 2003/2004 оны өвлийн семестертэй харьцуулбал 3%-иар буурч 1.966.243-д хүрсэн байна. 2003/2004 оны хичээлийн жилд Германд оюутны тоо 2.091.831 болсноор анх удаа 2 саяын босгыг давсан байна. Холбооны Статистикийн Газрын мэдээгээр оюутны тоо буурсан нь Нордрайн-Вестфален болон Хессен муж улсуудад удаан хугацаагаар суралцаж буй оюутнууд сургалтын төлбөр төлөх болсонтой холбоотой бөгөөд Нордрайн-Вестфаленд 62.253 оюутан, Хессенд 17.117 оюутан сургуулиасаа гарсан байна. Урьд жилийнхтэй харьцуулахад Германы их, дээд сургуульд суралцаж буй гадаад оюутны тоо 244.643 (2003/2004 онд 246.136) болж буурчээ. 2004/2005 оны өвлийн семестерт их, дээд сургуульд элсэгчдийн тоо 6%-иар буурч, бүрэн бус мэдээгээр 300.142 (316.656) болсон байна. Дээд сургуульд элсэгчдийн квот буюу дээд сургуульд элсэгчид өөрийн насныхан дотроо эзлэх хувь хэмжээ нь 2004 оны хичээлийн жилд 37,3% (2003 онд 38,9%)-тай байна. Энэ нь Германы нэгдлээс хойш анх удаа буурсан үзүүлэлт байсан хэдий ч 1993 оны дүнгээс даруй 11,8 хувиар илүү байна.

Нийт оюутнуудаас 1.363.413 (2003/2004 онд 1.436.679) нь Их сургуулиуд (Багшийн болон Шашны сургуулиудыг оролцуулан)-д, 562.713 (551.941) мэргэжлийн болон захиргааны дээд сургуульд, 31.204 (31.211) нь Урлагийн Дээд Сургуульд суралцаж байв. 2004/2005 оны өвлийн семестерт оюутнуудын хамгийн их сонгосон хичээлийн төрлүүдийг жагсаавал, эрх зүй, эдийн засаг, нийгмийн ухааны чиглэлийг 613.050, хэл, соёл судлалын шинжлэх ухааны чиглэлийг (415.578), математик, байгалийн шинжлэх ухааны чиглэлийг (344.475), инженерийн чиглэлийг (323.864) оюутан сонгосон байна.

2004/2005 оны өвлийн семестерт хамгийн олон оюутан суралцаж бийсан их, дээд сургуулиудын тоонд:

1. Кельний Их Сургууль – (45.928)
2. Мюнхений Людвиг-Максимиланы Их Сургууль – (45.071)
3. Хамбургийн Их Сургууль – (38.723)
4. Мюнстерийн Их Сургууль - (38.290)
5. Берлиний Чөлөөт Их Сургууль – (37.590)
6. Франкфурт/Майны Их Сургууль – (34.459)
7. Майнцын Их Сургууль – (34.257);
8. Дуисбург-Эссений Их Сургууль – (33.557)
9. Хагений зайны сургалттай Их Сургууль – (33.557)

Боловсролд зарцуулсан хөрөнгө. Боловсрол, шинжлэх ухаан, соёлд улсаас төсөвлөсөн хөрөнгө мөнгөний хэмжээ 2004 онд дахин өсч, 91,90 тэрбум евро (эцсийн бус мэдээгээр 2003 онд зарцуулсан хөрөнгө 90,711 тэрбум евро) болсон байна. Үүнээс Холбооны улс 11,534 (2003 онд 10,547) тэрбум евро, муж улсууд 65,528 (65,316) тэрбум евро, хороод болон зорилтот холбоод 14,848 (14,848) тэрбум еврог гаргасан байна. Холбооны улс, муж улсууд болон хороод нь эцсийн бус мэдээгээр 2003 онд 49,591 (2002 онд 49,409) тэрбум еврог дунд сургуулиудад, 18,803 (18,779) тэрбум еврог их, дээд сургуулиудад, 11,692 (11,465) тэрбум еврог залууст зориулсан ажил, хүүхдийн өдөр өнжүүлэх байгууллагад тус тус зориулжээ.

ХБНГУ-ын эдийн засаг

Эдийн засгийн байдал Эдийн засгийн сул үе гурван жилийн туршид үргэлжилсний хойно 2004 онд Германы эдийн засгийн байдал сэргэж амсхийх шинж төлөв илэрч байна. ДНБ нэрлэсэн үнийн дүнгээр 2,0%-ийн өсөлттэй гарсан байна. Энэхүү өсөлт гарахад экспорт нэмэгдэж өргөжсөн явдал шийдвэрлэх үүргийг гүйцэтгэсэн бөгөөд асар эрчимтэй хөгжиж буй дэлхийн худалдаанд Германы экспорт 8,6%-ийн бодит өсөлттэй гарсан байна. Газрын тосны үнэ ихээхэн нэмэгдсэн, еврогийн ханш чангарсан зэргийн улмаас 2004 оны хоёрдугаар хагас жилд экспортын конъюнктурт удаашрал бий болсон. Ерөнхийдөө дотоодын эрэлт хэрэгцээ урьдын адил буурангуй байгаа тул эдийн засгийн өргөн хүрээтэй, энерги бүхий өсөлт явагдсангүй.

Засаг захиргааны болон түүнд шууд чиглэсэн бодлогын чанартай арга хэмжээ авч буй хөдөлмөрийн зах зээлд эдийн засгийн байдлын өөрчлөлт бараг нөлөөлөөгүй. Гэсэн хэдий ч 2004 оны эхэн үеэс хойш хөдөлмөр эрхлэгчдийн тоо дахин өссөн нь төрийн зүгээс ажлын байрыг нэмэгдүүлэхэд үзүүлсэн дэмжлэг тусламжтай холбоотой юм. Нийгмийн даатгалд хамрагдсан ажил эрхлэлт урьд жилүүдийн нэгэн адил буурсан. 2005 оны 1 дүгээр сарын 1-нд хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Хартц-IV шинэчлэлтийн ажлын хүрээнд ажилгүйчүүдийн мөнгө II хэмээхийг нэвгрүүлж эхэлснээр Хөдөлмөрийн захиргаанаас тэтгэгдэж байсан ажлын чадвартай, нийгмийн тусламжийн мөнгө хүртдэг хүмүүсийн тоог шинэчлэн тогтооход 2005 оны эхэнд ажилгүйчүүдийн тоо 5 сая гаруй болж нэмэгдсэн.

Барилгын үйлдвэрлэлээс бусад бүх эдийн засгийн салбар 2004 онд эдийн засгийн өсөлт явагдахад хувь нэмрээ оруулжээ. Хамгийн их өсөлт үйлдвэрлэлийн салбарт (+4,7%) явагдсан бөгөөд дараагийн байруудад хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загасны аж ахуй (+3%), худалдаа, зочид буудал, зам тээвэр (+2,1%), санхүү, түрээс, аж ахуйн үйлчилгээ (+1,6%), олон нийтийн болон хувийн үйлчилгээ эрхлэгчид (+0,1%) орж байна.

Улсын төсвийн хэдийгээр зарлага нь бага зэрэг буурсан боловч урьд жилүүдийн нэгэн адил ажилгүйдэл болон эдийн засаг, нийгмийн шинэчлэлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд тохиох бэрхшээлүүдийн улмаас асуудалтай хэвээр байв. Санхүүгийн байдал төсөв тус бүр дээр үнэхээр ялгаатай байсан. Муж улсууд төсвийн алдагдлаа бууруулж чадсан байхад харин холбооны санхүүгийн байдал төлөвлөснөөс ч илүү таагүй байсан. Худалдаа, үйлчилгээний салбараас авсан татварын орлого ихээхэн нэмэгдсэний дүнд хороод алдагдлаа тал хувиар бууруулж чаджээ. Орлогын хүрээ явцуурч, юмны үнэ нэмэгдэж, хадгаламжийн квот дахин нэмэгдсэнээр 2004 онд өрхийн аж ахуйн хэрэглээ улам буурчээ.

ДНБ: Холбооны Статистикийн Албаны мэдээгээр 2005 оны макро эдийн засгийн нийт тооцоог боловсронгуй болгосны дагуу ДНБ 2004 онд тухайн үеийн ханшаар 2207,24 тэрбум евро-д хүрсэн бөгөөд 2003 онд (Макро эдийн засгийн боловсронгуй тооцоонд

шигжүүлэхэд) энэ нь 2164,87 тэрбум евро болжээ. 2004 онд ДНБ урьд жилтэй харьцуулахад 2%-иар өссөн бөгөөд макро эдийн засгийн боловсронгуй тооцооны дагуу 1,6%-иар өссөн байна.

ДНБ-ий хэрэглээ: Өрхийн аж ахуйн хэрэглээний зардал 2004 онд урьд жилтэй харьцуулахад 1,3%-иар өсч, 1304,19 (2003 онд 1286,27) тэрбум евро болсон байна. Улсын хэрэглээний зардал ч 2004 онд урьд жилтэй харьцуулахад 0,4%-иар буурч, 412,93 (412,93) тэрбум евро болжээ.

Нийт хөрөнгө оруулалт: 2004 онд нийт хөрөнгө оруулалт 0,7%-иар буюу үл ялиг буурч, 379,52 (2003 онд 380,71) тэрбум евро болжээ. Тоног төхөөрөмжид хийсэн хөрөнгө оруулалт нэрлэсэн үнийн дүнгээр урьд жилтэй харьцуулахад 1,0%-иар өсч, 148,44 (146,94) тэрбум евро-д хүрсэн ажээ. Барилга байгууламжид хийсэн хөрөнгө оруулалт 2004 онд нэрлэсэн үнийн дүнгээр урд жилийнхээс 1,2%-иар буурч, 206,34 (209,22) тэрбум евро-д хүрчээ. Бусад хөрөнгө оруулалт нэрлэсэн үнийн дүнгээр бага зэрэг буюу 0,5%-иар өсч, 24,74 (24,55) тэрбум евро-д хүрсэн байна.

Инфляц: Хэрэглэгчийн үнэ 2004 онд урьд жилүүдийнхээс арай илүү буюу 1,6%-иар (2003 онд 1,1%; 2002 онд 1,4%) өссөн байна. Үнэ ийнхүү өсөхөд нөлөөлсөн хүчин зүйлсийг дурдвал 2004 оны 1 дүгээр сарын 1-нд эрүүл мэндийн салбарт шинэчлэлийн арга хэмжээ хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн, 2004 оны 12, 3 дугаар саруудад тамхины татварыг нэмэгдүүлсэн болон газрын тосны үнэ өссөн зэрэг явдлууд нөлөөлсөн байна.

Үндэсний орлого: Үндэсний орлого 2004 онд 2,2%-иар өсч, 1639,09 (2003 онд 1600,88) тэрбум евро-д хүрсэн ба үүнээс 501,79 (469,04) тэрбум евро нь аж ахуйн нэгжийн болон өмчийн орлого, 1134,30 (1131,84) тэрбум евро нь ажиллагсдын цалин хөлс (хөлсний ажлаас олсон орлого, үүнд ажил олгогчдын төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг оролцуулан тооцно) зэрэг болно.

Ажиллагсдын цалин хөлс: Ажиллагсдын цалин хөлс (тэрбум еврогоор):

- Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загасны аж ахуй - 8,91 (8,93)
- Үйлдвэрлэлийн салбар (барилгын салбарын оруулалгүйгээр)

- 337,50 (335,89)
- Барилгын салбар - 53,93 (55,72)
- Худалдаа, гуанз, буудлын үйлчилгээ, зам тээвэр - 224,60 (225,57)
- Санхүүжилт, түрээс, аж ахуйн үйлчилгээ - 181,82 (178,83)
- Нийтийн болон хувийн үйлчилгээ - 328,30 (327,97)

Мөнгөн хөрөнгө: Өрхийн аж ахуйн мөнгө хөрөнгө 2004 онд бага зэрэг өсч, 4067 (2003 онд 3915) гэрбум еврод хүрсэн бөгөөд Германы Төв Банкны мэдээгээр 2004 оны эцэст ийнхүү анх удаа 4 тэрбум еврогийн "хязгаар"-ыг давсан байна. Үүнээс 1451 (1399) тэрбум еврог банкинд байршуулсан бөгөөд 1040 (991) еврог даатгалд, 1344 (1296) тэрбум еврог үнэт цаасаар, үүнээс 251 (245) тэрбум еврог акциар тус тус байршуулсан байна. Мөн өрхийн аж ахуйн өр улам өсч, 1566 (1562) тэрбум евро болоод байгаа бөгөөд үүнээс 90 (99) тэрбум еврог богино хугацааны зээл, 1466 (1454) тэрбум еврог урт хугацааны зээл авахад тус тус зарцуулсан байна.

Хадгаламжийн хэмжээ: Хувийн хадгаламж урьд жилийнхтэй харьцуулахад бага зэрэг өсч 155,3 (2003 онд 154,1) тэрбум евро болсон бөгөөд хадгаламжийн квот орлогын 10,6% (10,7%)-тай тэнцэж байв.

Гадаад худалдаа: Экспортын баримжаатай Германы эдийн засгийг 2004 онд экспорт дахин ихээхэн тэтгэж байв. Импорт тодорхой хэмжээгээр өссөн ч гадаад худалдааны ашиг 156,1 тэрбум еврод (2002 онд 132,8 тэрбум евро, 2003 онд 129,9 тэрбум евро) хүрч, шинэ рекордыг тогтоосон байна.

Төлбэрийн тэнцэл урьд жилтэй харьцуулахад бараг хоёр дахин өсч, 84,0 тэрбум евро (2003 онд 45,2 тэрбум евро) болсон байна. Харин 2004 онд үйлчилгээний салбарт зөрүү нь сөрөг гарч, -32,0 тэрбум евро (-34,0 тэрбум евро)-д хүрчээ. Үүний гол шалтгаан нь аялал жуулчлалын салбарт 35,8 тэрбум еврогийн буюу өндөр алдагдал хүлээсэнд оршиж байна.

Хөдөлмөр ба Нийгмийн асуудал

Хөдөлмөрийн зах зээлийн хөгжил: Захиргааны болон хөдөлмөрийн зах зээлд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээнүүд 2004 онд хөдөлмөрийн зах зээлд ихээхэн нөлөө үзүүлж, ул мөрөө үлдээсэн бөгөөд харин эдийн засаг гурван жил үргэлжилсэн зогсонги үе шатыг өнгөрөөсний дараа дахин сэргэсэн ажилгүйдлийг бууруулахад нөлөө үзүүлж чадаагүй билээ. Хөдөлмөрийн зах зээлд орчин үеийн үйлчилгээ нэвтрүүлэх тухай IV хуулийн хүрээнд ("Хартц IV") ажил хайж буй хүмүүст зориулсан шинэ үндсэн баталгаа 2005 оны 1 дүгээр сарын 1-нд хүчин төгөлдөр үйлчлэх болсон. Мөн энэ үеэс 15-65 насны ажлын чадвартай боловч тусламж шаардлагатай хүмүүс, хөдөлмөрийн зах зээлийн түгээмэл нөхцөлд өдөрт дор хаяж гурван цаг ажиллах чадвартай хүмүүс болон түүний гэр бүлийнхэнд ажилгүйчүүдийн мөнгө II-ийг шинээр олгох болсон бөгөөд ажлын чадваргүй гэр бүлийн гишүүд нийгмийн мөнгөн тэтгэлгийг хүртэх боломжтой болжээ. Ажилгүйчүүдэд үзүүлж байсан хуучин тусламжийг хүчингүй болгосон бөгөөд үүний хамтаар түүний гэр бүлийн хүрээний хүмүүст үзүүлж байсан амьжиргааны тусламж үгүй болсон ажээ. Ингэснээр ажилгүйчүүдийн тоо 2005 оны 1 дүгээр сарын байдлаар 5 саяын хязгаараас давж гарсан бөгөөд гэвч дараагийн саруудад энэ хязгаараас доош буусан юм. Хөдөлмөр эрхлэгчдийн тоо 2001 оноос хойш удаа 2004 онд дахин өссөн бөгөөд энэ нь бие даагсад буюу цөөхөн ажиллагсадтай Би-Хувьцаат компани төрийн бодлогын тусламжтайгаар олширсонтой холбоотой юм. Нийгмийн даатгал төлөх үүрэг бүхий ажиллагсдын тоо буурах хандлага 2004 онд мөн л үргэлжилсээр байна.

Хөдөлмөр эрхлэлт: Эцсийн бус мэдээгээр ажиллагсдын тоо (ажил эрхлэгчид болон ажилгүйчүүд) дотоодын оршин суугчдад зориулсан үзэл баримтлалын дагуу 2004 оны дунджаар 0,9%-иар өсч, 42,708 сая еврод (2003 онд 42,322 сая эцсийн бус мэдээгээр) хүрээд байна. Ажил эрхлэгчдийн тоо хэдэн жилийн тэртээгээс хойш 2004 онд анх удаа 142.000-аар нэмэгдэж 38,777 сая-д хүрчээ. Үүнээс 4,231 сая нь бие даан хөдөлмөр эрхлэгчид байсан бөгөөд энэ нь урьд жилийнхээс 3,9%-иар илүү байв.

Эцсийн бус мэдээгээр дотоодод хөдөлмөр эрхлэгсдийн тоо эдийн засгийн салбар тус бүрээр (2003 оны эцсийн бус мэдээгээр) үзүүлбэл:

- Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуур - 0,886 (0,881) сая
- Үйлдвэрлэлийн салбар (Барилгын салбарыг оролцуулалгүйгээр) - 8,018 (8,139) сая
- Барилгын салбар - 2,25С (2,322) сая
- Худалдаа, гуанз, буудлын үйлчилгээ, зам тээвэр - 9,770 (9,717) сая
- Санхүү, түрээс, аж ахуйн үйлчилгээ – 6,304 (6,128) сая
- Нийтийн болон хувийн үйлчилгээ – 11,632 (11,535) сая

Төрийн алба: Холбооны Статистикийн Газрын мэдээлснээр төрийн байгууллагад ажиллагсдын тоо 2004 оны 6 дугаар сарын 1-ны байдлаар дахин бага зэрэг буурсан бөгөөд эцсийн бус мэдээгээр 4,684 (2003 онд 4,779) сая хүн төрийн байгууллагад ажиллаж байв. Энэ нь нийт ажиллагсдын 14,0 (14,0)% нь болж байв. Нийт төрийн байгууллагад ажиллагсдын 4.082.065 (4.184.274) нь шууд төрийн байгууллагад ажиллаж буй бөгөөд үүнээс:

- 492.685 (233.963) нь Холбооны улсад,
- 2.115.728 (2.155.281) нь муж улсуудад,
- 1.348.084 (1.409.592) нь хороод болон тэдгээрийн холбоодод,
- 70.530 (70.342) нь тусгай зорилго бүхий хороодын холбоодод,
- 55.038 (57.944) нь холбооны төмөр замын санд ажиллаж байв.

Харин шууд бус төрийн байгууллагад ажиллаж буй 601.783 (595.130) ажиллагсдаас

- 233.381 (242.929) нь Холбооны улсын албанд,
- 368.402 (352.201) нь Муж улсуудын албанд тус тус ажиллаж байв.

Төрийн байгууллагад ажиллагсдыг хашиж буй албан ажлаар нь авч үзвэл төрийн албан хаагч, шүүгч, цэрэг бүгд 1.880.412 (1.876.587) байсан бөгөөд үүнээс 187.700 (186.889) нь цэрэг, 2.229.247 (2.301.493) нь албан хаагч, 574.189 (601.106) нь ажилчид байв.

Ажилгүйдэл: Эдийн засгийн байдал дээрдэж, амсхийсэн боловч энэ нь хөдөлмөрийн зах зээлд хараахан нөлөө үзүүлээгүйгээс 2004 онд ажилгүйчүүдийн тоо өөрчлөгдсөнгүй, өндөр хэвээр байв. 2004 онд дунджаар 4.381.040 хүн ажилгүй хэмээн бүртгүүлсэн нь 2003 онтой харьцуулахад 5013-аар буюу 0,1%-иар илүү байгаа бөгөөд 2004 оны 1 дүгээр сарын 1-нд ажилгүйчүүдийн статистикийг өөрчилсний улмаас зөвхөн зарим тохиолдолд л урьд жилийнхтэй харьцуулах боломжтой гэдгийг анхааран үзэх ёстой юм. Нийгмийн хууль тогтоомж II (SGB II)-ийг мөрдсөнөөр хөдөлмөрийн болон нийгмийн тусламжийг нэгтгэж, үүнтэй холбоотойгоор статистик нөлөө үзүүлсний улмаас 2005 оны 1 дүгээр сарын 1-нд Холбооны Хөдөлмөрийн агентлаг 2004 оны жилийн эцсийн тайландаа 5.037.142 ажилгүй хүн байгааг мэдэгдсэн байна. Холбогдох байгууллагын тооцоолсноор үүнээс дор хаяж 222.000 нь ажлын чадвартай боловч нийгмийн тэтгэмж авдаг байсан хүмүүс ажээ.

Холбооны Хөдөлмөрийн агентлагийн мэдээгээр 2005 оны 5 дугаар сард 4.806.589 ажилгүй хүн байсан бөгөөд ажилгүйдлийн төвшин 11,0%-тай байв. Үүнээс 3.169.980 нь Баруун Германд (9,7%), 1.636.609 нь Зүүн Германд (18,9%) амьдарч байв.

Баруун Герман дахь ажилгүйдэл: Хуучин муж улсуудад (Берлинийг оролцуулалгүйгээр) ажилгүйчүүдийн дундаж тоо 2004 онд 2,781 (2003 онд 2,753) сая болж өссөн байна. 25-аас доош насны ажилгүй залуучуудын тоо 323 (328) мянга болж буурсан ба 55 ба түүнээс дээш насны ажилгүйчүүдийн тоо 324 (355) мянга болж буурсан байна. Харин ажилгүй тахир дутуу (хүнд бэртэлтэй) иргэдийн тоо 130(125) мянга, удаан хугацааны туршид ажилгүй байсан хүмүүсийн тоо 983 (872) мянга болж тус тус өсчээ. Ажилгүй гадаадын иргэдийн тоо 472 (471) мянга байж, бараг тогтмол хэвээрээ үлдсэн байна. 2004 оны дундажаар ажилгүйдлийн төвшин бага зэрэг өсч, 8,5% (2003 онд 8,4%)-тай болсон байна. Ажлын хагас цагаар

хөдөлмөр эрхлэгчдийн тоо 122 (160) мянга болтлоо буурсан. Ажлын байр шинээр бий болгох арга хэмжээнд 2004 онд 20 (24) мянган хүн хамрагдсан бөгөөд Холбооны Хөдөлмөрийн Агентлагаас дэмжлэг үзүүлсэн мэргэжил дээшлүүлэх арга хэмжээнд 121 (161) мянган хүн хамрагджээ.

Зүүн Герман дахь ажилгүйдэл: Шинэ муж улсуудад (Берлинийг оролцуулан) 2004 онд ажилгүйчүүдийн тоо дундажаар бага зэрэг буурсан ч 1,538 (2003 онд 1,624) саятай байна. Нийт 182 (183) мянган хорин таваас доош насны залуус ажилгүй байгаа бөгөөд 55 болон түүнээс дээш насны хүмүүсийн ажилгүйдэл 159 (177) мянга болж буурсан байна. Харин үүний эсрэгээр хүнд бэртэлтэй, тахир дутуу ажилгүй иргэдийн тоо 45 (42) мянга, удаан хугацааны туршид ажилгүй байсан хүмүүсийн тоо 698 (649) болж тус тус өссөн байна. 78 (77) мянган гадаад иргэд 2004 онд ажилгүй хэмээн мэдүүлжээ. Жилийн дундажаар ажилгүйдлийн төвшин 18,4% (18,5%) байв. Ажлын хагас цагаар хөдөлмөр эрхлэгчдийн тоо 29 (35) мянга болж, харин 65 (73) мянган хүн ажлын байр шинээр бий болгох арга хэмжээнд 2004 онд оролцсон байна. 63 (99) мянган хүн Холбооны Хөдөлмөрийг агентлагаас зохион байгуулсан мэргэжил дээшлүүлэх арга хэмжээнд хамрагджээ.

Мэргэшлийн зах зээл: 2000 оноос хойш анх удаа 2004 онд мэргэшлийн зах зээлийн байдал сайжирсан. 1.10.2003-30.9.2004 хугацаанд нийт 572.980 (2002/2003 онд 557.634) мэргэшлийн гэрээг шинээр байгуулсан бөгөөд 586.374 (2002/2003 онд 572.474) байрны саналын 2,8% буюу 15346 гэрээ мөн багтаж байна. Ийнхүү нэмэгдэхэд 2004 оны 6 дугаар сарын 16-нд Холбооны Засгийн газар болон эдийн засгийнхны дунд байгуулагдсан "Мэргэшил ба мэргэжилтэй боловсон хүчний хэйч үед зориулсан үндэсний факт" нь Боловсрол, судалгааны яамны мэдээгээр хамгийн гол түлхэц үзүүлсэн байна. Үүний дагуу эдийн засгийнхан ирэх гурван жилийн хугацаанд жил бүр мэргэшил эзэмших 30.000 шинэ орон тоо, мэргэжлээрээ дадлагажих 25.000 орон тоог бий болгох үүрэг хүлээжээ. Дээрх хугацааны сүүлчээр буюу 2004 оны 9 дүгээр сарын 30-нд урьд жилтэй харьцуулахад тухайн жилд сургууль төгсөгчдийн тоо олон байсан тул мөн шууд өрсөлдөгчийн тоо ч илүү олон байсан бөгөөд эл өдөр 44.576 (2003 онд 35.015) залуус мэргэшил эзэмших

Боломжийг хайж байв. Жилийн эцэс гэхэд өрсөлдөгчдөөс 29.627-д нь зуучилж чадсанаар зуучлагдаж чадаагүй үлдсэн залуусын тоо 14.949 (16.273) болж, 66,5% (53,3%)-иар буурсан байна. Холбооны Статистикийн Албаны мэдэгдсэнээр мэргэшил эзэмших хамгийн дуртай салбарт аж үйлдвэр, худалдааны салбар орж байгаа бөгөөд үүнд 2004 онд 320.220 (309.700) шинэ гэрээг байгуулжээ. Харин 171.423 (171.800) суралцагч бүхий гар урлалын мэргэжил бага зэрэг хойш ухарсан байна.

Цалин хөлс: Холбооны Статистикийн Албаны мэдээгээр гар урлал, худалдаа, үйлчилгээний аж ахуйн нэгжүүдэд (үйлдвэрлэл, худалдаа, зээл, даатгалын компани, нутгийн эвлэл холбоод) сарын цалингийн тарифт хэмжээ 2004 онд урьд жилтэй харьцуулахад 2,0%-иар илүү байв. Сарын цалингийн тарифт хэмжээ дунджаас дээгүүр хэмжээгээр өссөн салбаруудыг дурдвал төмөр зам (+3,6%), сүлжмэл нэхмэлийн үйлдвэр (+2,7%), машины үйлдвэрлэл (+2,5%), металл бүтээгдэхүүний үйлдвэрлэл, зээлийн компани, нутгийн эвлэл, холбоод (тус бүр +2,4%) зэрэг болно. Худалдааны салбарт цалин 2,0%-иар өссөн байна. Ажил олгогчдын дундаж ашиг 2004 онд урьд жилтэй харьцуулахад зөвхөн 0,2%-иар өсчээ. Энэхүү тооцоог хийхдээ цалингийн тарифт хэмжээ өсөхөд зөвхөн зарим талаар оролцож буй цөөн тооны ажиллагсдыг ч харгалзаж үзсэн болно.

Нийгмийн халамжийн тэтгэмж: 2003 онд нийгмийн халамжийн тэтгэмж өсч, 694,4 тэрбум евро болсон нь ХБНГУ-ын түүхэнд өнөөг хүртэлх хамгийн өндөр үзүүлэлт болж байна. (2002 онд 683,0 тэрбум евро) Энэ үед нийгмийн халамжийн тэтгэмжийн хувь хэмжээ буюу нийгмийн халамжийн тэтгэмжийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ нь 32,6% (2002 онд 32,5%)-д хүрсэн байна. Тооцоолж үзвэл, хүн тус бүрд 8416 (€306) еврогийн нийгмийн халамжийн тэтгэмж ноогдож байв. 2003 оны нийгмийн халамжийн тэтгэмжийг бүрдүүлэхдээ ажил олгогчдын оруулсан хувь нэмрээс 237,7 (242,5) тэрбум еврог, улсын хөрөнгө мөнгөнөөс 272,7 (263,0) тэрбум еврог, даатгуулагчдын оруулсан хувь нэмрээс 183,1 (179,1) тэрбум еврог тус тус гаргуулсан байна.

ХБНГУ
Нийгмийн халамжийн тэтгэмж
(тэрбум еврогоор)

	2002	2003
1. Шууд тэтгэмж		
а. Ерөнхий систем:		
Ажилчдын тэтгэврийн даатгал	113,4	115,2
Албан хаагчдын тэтгэврийн даатгал	105,3	108,8
Гэнэтийн осолд орсон уурхайчдын тэтгэврийн даатгал	14,1	14,5
Асрамжийн даатгал	17,3	17,4
Эрүүл мэндийн албан ёсны даатгал	141,2	143,4
Гэнэтийн ослын албан ёсны даатгал	11,3	11,3
Ажил эрхлэлтийг дэмжих (Холбооны хөдөлмөр эрхлэлтийн албанаас олгосон тэтгэмж)	71,1	73,3
б. Тусгай систем:		
Фермерүүдийн өндөр насны даатгал	3,3	3,3
Төрийн албан хаагчдын ар гэрийнхний материаллаг баталгааг хангах	2,3	2,5
с. Төрийн байгууллагад зориулсан тэтгэмжийн систем:		
Тэтгэврийн мөнгө	35,4	35,8
Гэр бүлийн нэмэгдэл	7,0	7,0
Тусламж, тэтгэлэг	9,8	9,9
д. Ажил олгогчдод олгосон тэтгэмж:		
Цалинг тасралтгүй тавих	26,5	25,0
Үйлдвэрийн өндөр настны тэтгэлэг	16,2	16,1
Нэмэлт хангамж	8,5	8,7
Ажил олгогчдод олгосон бусад тэтгэмж	2,8	2,7
е. Нөхөн олговор:		
Нийгмийн нөхөн олговор	4,6	4,5
Дайны төлбөр хохирлыг барагдуулах	0,1	0,1
Нацист дэглэмийн улмаас хохирогсдод нөхөн олговор төлөх	0,9	0,9
Бусад нөхөн олговор	0,1	0,2
ф. Нийгэмд үзүүлэх тусламж, үйлчилгээ:		
Нийгмийн тусламж	26,7	28,0

Залуучуудад үзүүлэх тусламж	17,8	17,9
Хүүхдийн мөнгө	0,1	0,1
Хүүхдийн хүмүүжилд зориулах тусламж	3,6	3,5
Мэргэшлийг дэмжих	1,5	1,7
Байрны мөнгө төлөхөд туслах	4,9	5,2
Хөрөнгө бий болгоход дэмжих	0,8	0,9
2. Шууд бус тэтгэмж:		
Татварын арга хэмжээгээр олгох тэтгэмж (Хүүхдийн мөнгө болон бусад хүүхдийн асрамжинд зориулагдсан хөнгөлөлтүүдийг оролцуулалгүйгээр)	38,2	39,0
Хүүхдийн мөнгө болон бусад хүүхдийн асрамжинд зориулагдсан хөнгөлөлтүүд	36,0	36,1
Нийгмийн халамжийн тэтгэмж бүгд	683,036	694,430

Нийгмийн тусламж: 2003 оны 12 дугаар сарын 31-нд Германд 2,811 сая нийгмийн тусламж хүртэн амьдрагсад байсан. Ийнхүү 2002 оны 12 дугаар сарын 31-тэй харьцуулахад 2 орчим хувиар илүү хүмүүс амь зуулгаа залгуулахад нь байнгын тусламж шаардлагатай болсон байна. Баруун Германд (Берлинийг оролцуулалгүйгээр) тусламж хүртэгсдийн тоо урьд жилтэй харьцуулахад 1,2%-иар өсч, 2,125 саяд хүрсэн байна. Харин Зүүн Германд (Берлинийг оролцуулалгүйгээр) энэ тоо 420 мянга болж өссөн (+4,9%) бөгөөд Берлинд 261 мянган хүн (+3,5%) нийгмийн тусламж авчээ. Нийгмийн тусламж шаардлагатай 18-аас доош насны хүүхдүүдийн тоо гойд их өссөн байна. Энэ нь 2003 онд 2002 онтой харьцуулахад 6,2%-иар өсч, 1,08 сая-д хүрчээ.

Холбооны Статистикийн Албаны мэдээгээр 2003 оны эцэст хэрэглээний үндсэн баталгааг хангах тэтгэмжийг 438.831 хүн авсан. Ингэснээр 65-аас дээш насны нийгмийн тусламж хүртэгсдийн тоо 2003 оны эцэст 98 мянга болж, энэ нь 2002 онтой харьцуулахад 48%-иар буурсан бөгөөд настай хүмүүсийн нийгмийн тусламж хүртэх хувь хэмжээ 0,7% болж буурсан байна.

Нийгмийн тусламжинд гаргасан зардал 2003 онд урьд жилтэй харьцуулахад 3,0%-иар нэмэгдэж, 22,569 (2002 онд 21,914) тэрбум еврод хүрсэн нь хамгийн өндөр үзүүлэлт болжээ. Ийнхүү оршин суугч бүрт 274 евро цэвэрээр оногдсон байна. Нийт нийгмийн

тусламжийн 18,143 (2002 онд 17,701) тэрбум евро нь хуучин муж улсуудад (Берлинийг оролцуулалгүйгээр, 2,584 (2,439) тэрбум евро нь шинэ муж улсуудад (Берлинийг оролцуулалгүйгээр), 1,842 тэрбум евро нь Берлинд тус тус оногдсон байна. 2003 онд нийгмийн тусламжинд гаргасан цэвэр зардлаас 8,747 (2002 онд 8,761) тэрбум еврог амин зуулгаа залгуулахад тусламж болгож, 13,822 (13,153) тэрбум еврог амьдарлын онцгой байдалд байгаа хүмүүст тусламж үзүүлэхэд тус тус зарцуулсан байна.

Тэтгэвэр: Германы тэтгэврийн даатгалд хамрагдагсдын холбооны мэдээгээр 2004 оны 7 дугаар сарын 1-ны байдлаар 19,812 (2002 онд 19,558) сая тэтгэврийн хүмүүс байсан нь 2003 онтой харьцуулахад 1,3%-иар буюу бага зэрэг өсчээ. Тэтгэвэр авагчдын 11,597 (11,493) нь эмэгтэй, 8,216 (8,065) нь эрэгтэй бөгөөд тэд хууль ёсны тэтгэврийн даатгалаас тэтгэврээ авсан байна. Хэд хэдэн газраас тэтгэвэр авдаг эмэгтэйчүүд 3,511 (3,458) сая, эрэгтэйчүүд 3,452 (3,195) сая байв.

Эрүүл мэндийн даатгал: Эрүүл мэндийн хууль ёсны даатгалд хамрагдагсдын тоо бага зэрэг буурч, 2004 оны дунджаар 50,652 (2003 онд 50,754) саяд хүрсэн байна. Үүнээс 28,748 (28,957) сая нь зайлшгүй даатгалд хамрагдах ёстой гишүүд, 16,816 (16,681) сая нь тэтгэврийн хүмүүс, 5,061 (5,116) сая нь сайн дурын даатгуулагчид байв.

Эрүүл мэндийн хувийн даатгалд хамрагдагч гишүүдийн тоо 8,26 (2003 онд 8,11) сая байв. Ажил олгогчоос тухайн этгээдийг эрүүл мэндийн хувийн даатгалд шилжүүлэх цалингийн хязгаар нь 2004 онд 46.350 евро (нэг жилийн орлогын хэмжээ) байв. Хувийн нэмэлт даатгалын гэрээний (албан ёсны болон хувийн даатгуулагчдын зүгээс байгуулсан) тоо урьд жилтэй харьцуулахад бага зэрэг өсч, 16,23 (14,68) саяд хүрсэн байна.

Улсын санхүү: Улсын төсвийн (төрийн төсвийг оролцуулан) нэгдсэн тоо хараахан гараагүй байна. 2004 онд Германы Төв Банкны мэдээгээр (хэсэгчлэн дүгнэсэн) орлого, зарлагын зөрүү -65,0 тэрбум евро болсон ба 2003 онд энэ нь -74,1 тэрбум евро болжээ. 2004 (2003) онд орлого 925,1 (925,9) тэрбум евро болсноос 443,0 (442,2) тэрбум евро нь татварын орлого ажээ. 2004 (2003) онд

зарлага 990,1 (1000,0) тэрбум евро болж, доорх хэсгүүдээс бүрдэж байна.

Үүнд:

Нийгмийн даатгалын зардал – 468,7 (474,4) тэрбум евро

Боловсон хүчний зардал – 173,5 (174) тэрбум евро

Хүүгийн зардал – 64,8 (65,7) тэрбум евро тус тус орж байна.

Төсвийн алдагдал 2004 онд урьд жилтэй харьцуулахад 0,2%-иар буурсан - 3,6%-тай байж, ингэснээрээ Маастрихтын гэрээнд заасан ҮНБ-ний 3% гэсэн хязгаарыг гурав дахь удаагаа давсан байна. Улсын өр ҮНБ-ний 60%-иас хэтэрч болохгүй гэсэн Маастрихтын хоёр дахь чухал шалгуурыг зөрчсөн байна. Өрийн хэмжээ 1,8%-иар хэтэрч 66%-д хүрсэн нь шинэ рекордыг тогтоогоод байна. Эцсийн бус тооцоогоор 2004 онд улсын нийт алдагдал урьд жилийнхээс 3 тэрбум еврогоор давж, 80,3 тэрбум еврод хүрчээ.

Холбооны төсөв: 2005 оны 7 дугаар сарын 13-нд Засгийн газарт хүлээлгэн өгсөн Холбооны төсөв-2006 нь Үндсэн хуулийн заалтыг, плангуяа хөрөнгө оруулалтад зориулах зардал нь төлөвлөж буй шинэ өрийн хэмжээнээс илүү байх ёстой гэсэн заалтыг арай чүү л биелүүлж байна. 2006 онд 21,5 тэрбум еврогийн зээл авч, 22,4 тэрбум еврогийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж байна.

2004-2005 оны Холбооны төсөв

	Нарийвчилсан төлөвлөгөө	Төлөвлөгөө 2004 Тодотголыг хамт тооцсон	Төлөвлөгөө 2005
		сая еврогоор	
01	Холбооны Ерөнхийлөгчийн Тамгын Газар	23,04	23,64
02	Бундестаг	548,91	550,92
03	Бундесрат	18,25	19,95
04	Холбооны Канцлерийн ажлын алба	1490,29	1510,08
05	Гадаад Хэргийн Яам	2173,58	2205,78
06	Дотоод Явдлын Яам	4057,98	4126,64
07	Хууль зүйн Яам	340,12	338,59
08	Сангийн Яам	3520,92	4041,77
09	Эдийн засаг, хөдөлмөрийн яам	30915,33	37974,67
10	Хэрэглэгчдийг хамгаалах, хүнс тэжээл, хөдөө аж ахуй	5211,63	5106,96
12	Зам тээвэр, барилга, байр сууц	26778,80	23255,51
14	Батлан хамгаалах	24060,71	23900,00
15	Эрүүл мэнд, нийгмийн аюулгүй байдал	83465,10	84409,88
16	Хүрээлэн буй орчин, байгаль хамгаалал, цөмийн цахилгаан станцын аюулгүй байдал	789,41	769,02
817	Гэр бүл, ахмадууд, эмэгтэйчүүд, залуучууд	4872,49	4571,69
19	Холбооны Үндсэн Хуулийн цэц	17,03	17,63
20	Холбооны хянан шалгах газар	88,71	86,67
23	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжил	3783,43	3859,09
30	Боловсрол, судалгаа	8261,25	8540,42
32	Холбооны өр	38844,14	40431,84
33	Хангамж	8792,72	8821,01
60	Санхүүгийн ерөнхий захиргаа	7546,17	- 261,77
	Нийт	255600,00	254300,00*

* Эх сурвалж: Холбооны сангийн яам, 2005

ХБНГУ

Холбоо, муж улсууд, хороодын татварын орлого (сая еврогоор)

Татварын төрөл	2003	2004
Нийтлэг татвар		
Цалингийн татвар ¹	133.090	123.896
Зайлшгүй төлөх орлогын албан татвар ¹	4.568	5.394
Капиталын ашгийн татвар ²	16.633	16.691
Байгууллагын албан татвар ²	8.275	13.123
Нэмэгдэл өртөгийн албан татвар ³	103.162	104.715
Экспортын барааны татвар ³	33.834	32.651
Цэвэр холбооны татварууд		
Газрын тосны татвар	43.188	41.782
Тамхины татвар	14.094	13.630
Нэрмэл архины хураамж	2.204	2.195
Даатгалын татвар	8.870	8.750
Бусад тээврийн татвар		
Цахилгааны татвар	6.531	6.597
Холбооны бусад албан татварууд ⁴	11.722	11.601
ЕХ-гаалийн татвар	2.877	3.059
Цэвэр муж улсуудын татвар		
Хөрөнгийн татвар	230	80
Механикжсан тээврийн хэрэгслийн татвар	7.336	7.740
Шар айрагны татвар	786	788
Өв замгамжлалын татвар	3.373	4.284
Муж улсуудын бусад татварууд	6.989	6.883
Хороодын татвар		
Аж ахуйн нэгжийн татвар (ашиг/капитал)	24.146	28.373
Үндсэн татварууд	9.658	9.939
Хороодын бусад татварууд болон татвар гест орлогууд	671	797
Татварын орлого – бүгд	414.846	409.517

¹ Холбооны улсын хэмжээнд 42,5%, муж улсууд 42,5%, хороод 15%

² Холбооны улсын хэмжээнд 50,0%, муж улсууд 50,0%

³ Холбооны улсын хэмжээнд 49,6%, муж улсууд 50,4%

⁴ Хэрэглээний үлдсэн татварууд болон муж улсуудын төвшинг тэнцүүлэх хураамж

Эх сурвалж: Холбооны Төв Банк, 2005 оны 6-р сар.

Үйл явдлын товчоон

Дотоодын эдийн засгийн байдал илтэд сэргэж, хөдөлмөрийн зах зээл дээр амсхийлт бий болно гэдэгт улаан-ногоон намуудын эвслийн Засгийн газар итгэж байсан ч энэ нь биеллээ олсонгүй. 2005 оны 2 дугаар сард ажилгүйчүүдийн тоо 5,22 саяд (12,6%) хүрч, (үүнд статистикийн шинэ аргачлал нөлөө үзүүлснийг харгалзан үзэх хэрэггүй), ХБНГУ-ын түүхэнд ажилгүйдэл хамгийн өндөр хэмжээнд хүрсэн байна. Засгийн эрх баригч намууд сонгууль болох 2006 он болоход олон түмний улс төрийн санаа бодолд өөрчлөлт гарах байх гэж найдаж байсан ч ийм нөхцөлд хүссэн өөрчлөлт гарсангүй. Холбооны Канцлер Герхард Шрёдерийн эхлүүлсэн "Агенда 2010"-ын гол цөм болсон хөдөлмөрийн зах зээлийн шинэчлэлийг хүлээн зөвшөөрөхгүй байх нь улам бүр нэмэгдэх болсон. Учир нь "Хартц IV"-ийг амьдрал дээр хэрэгжүүлж эхэлсэн эхний саруудад нийгмийн хатуу, өршөөлгүй, шударга бус байдал тодорч, гар урлалын хомсдол бий болж, ажилгүйдэлтэй тэмцэхэд ахиц амжилт гарсангүй. Шлесвиг-Хольштайн муж улсад 2 дугаар сард, Нордрайн-Вестфален муж улсад 5 дугаар сард болсон сонгуулийн дүнгээс харахад ГСДН сонгогчдын итгэл буурч байгаа явдлыг зогсоож чадаагүй болох нь илэрсэн чухам энэ үед Холбооны Канцлер Шрёдер дараагийн сонгуулийн хугацааг наашлуулж, дахин шинээр эрх барихыг эрмэлзсэн билээ. Тэрээр энэхүү алхмыг хийснээрээ намуудад өөрчлөлт орох алхмыг эхлүүлсний зэрэгцээ итгэл үзүүлж болох эсэх асуудлыг Үндсэн Хуулийн Цэцийн эрхийн хүрээнд Бундестагт хэлэлцэн маргаж байв. Үүний үр дүнд ГСН-д тулгуурласан нэгдмэл нам ("Зүүний нам") байгуулагдаж, намуудын хүрээнд гуравдагч хүчтэй нам болох магадлал өсөн нэмэгдэж байсан нь ГСДН-д хамгийн хүндээр туссан.

Бундестагийн сонгуулийг наашлуулах болсноор ХАХ-ны дарга Ангела Меркельд өөрийн намаас Канцлерт нэр дэвших үүрэг оногдсон бөгөөд энэ нь өмнө таамаглаж байснаас илүү хурдан, амархан шийдэгдсэн байна.

Дотоод үйл явдлууд

Бундестагийн сонгууль хийх замд: 2005 оны 5 дугаар сарын 22-нд Нордрайн-Вестфалены сонгуулийн түр байрыг хаасны дараахан ГСДН-ын дарга Франц Мюнтеферинг болон Холбооны Канцлер Герхард Шредер нар телевизээр үг хэлэхдээ, Бундестагийн дараагийн сонгуулийг урагшлуулах эрмэлзэлтэй байгаагаа мэдэгдсэн. Энэ алхмыг бүх намууд талархан дэмжиж, хэвлэл мэдэллийн хэрэгслүүдэд сонгуулийн энгийн тов болох 2006 оны намар хүртэл Холбооны бодлого бүрэн зогсонги байдалд орохоос зайлсхийх "зоримог алхам" гэж үнэлж байв. Үндсэн хуулинд Бундестаг өөрөө огцрох тухай заалт байдаггүй бөгөөд түүнийг огцруулах бусад арга замууд тийм ч таатай биш тул 2005 оны 6 дугаар сарын 27-нд Шредер түүнд итгэл үзүүлэх эрх асуудлыг Бундестагт тавьсан. Энэ нь Бундестагийн гишүүдийн дийлэнх олонхийн буюу шаардагдах саналыг авахгүй байх санааг явуулж байв. Энэ нь үндсэндээ Холбооны Канцлер Вилли Брандт (ГСДН), Хельмут Коль (ХАХ) нар 1972, 1982 онуудад дараагийн шинэ сонгуульд ямар ч гэсэн албан тушаалдаа үлдэхийн тулд хэрэглэсэн бохир сонгуулийн удаах жишээ болсон байна.

2005 оны 7 дугаар сарын 1-нд Шредер дээрх асуудлыг тавих болсон үндэслэлийг тайлбарлахдаа харилцан шүтэлцэл учир дутагдалтай байгаагийн улмаас түүний явуулж буй бодлогод Бундестагийн олонх ямагт итгэж буй эсэх нь тодорхойгүй байна гэжээ. ГСДН сонгуульд ээлж дараалан хүнд ялагдал хүлээсний дараа, сөрөг хүчнийхэн нь түүнийг бүслэн хаах стратеги баримталж байсны улмаас тэдний зонхилдог Бундесратад Шредерийн Засгийн газар зөвхөн хязгаарлагдмал хүрээнд үйл ажиллагаа явуулах болно гэжээ. Иймд, шинэчлэлийн хөтөлбөрийг цааш үргэлжлүүлэхэд иргэдээс шинээр зөвшөөрөл авах хэрэгтэй болоод буй гэжээ.

Бундестагийн санал хураалтанд 151 гишүүн (105 ГСДН, 46 Ногооны нам) Холбооны Канцлерт итгэл үзүүлжээ. ГСДН-ын болон фракцийн дарга Франц Мюнтеферингийн зөвлөсний дагуу 148 гишүүн (140 социаль демократууд, 8 ногоонтнууд) түтгэлзсэн санал өгсөн байна. 296 парламентч татгалзсан санал өгчээ. Үндсэн хуулийн эрх зүйд холбогдох эргэлзээ бий болсны улмаас 5 гишүүн, үүнд, тухайлбал Ногоон намын улс төрч Вернер Шульц зэрэг саналаа өгөөгүй байна. Түүний нэгэн адил ГСДН-ын гишүүн

Елана Хофманн хэрвээ Бундестагийг огцруулах аваас Холбооны Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргана гэдгээ зарласан байна. Итгэл үзүүлэх эсэхийг шийдвэрлэх санал хураалт нь Үндсэн хуулийн 68 дугаар зүйлд заасан урьдач нөхцөлүүдийг хэлбэр болон агуулгын хувьд хангаж чадаагүй ажээ.

Санал хураалтын дараа Холбооны Канцлер Үндсэн хуулийн 68 дугаар зүйлийн дагуу Бундестагийг огцруулах саналыг Холбооны Ерөнхийлөгчид тавьжээ. Холбооны Ерөнхийлөгч Хорст Көлер 7 дугаар сарын 21-нд саналыг хүсэлт ёсоор биелүүлж, уг шийдвэрээ гаргах болсон үндэслэлийг тайлбарлахдаа улс орны өнөөгийн төвөгтэй байдлын улмаас "Бундестагт найдвартай, чадварлаг олонх байх шаардлагатай" гэжээ. Бундестагийн сонгууль явуулах товыг тэрээр 9 дүгээр сарын 18-ны өдөр гэж тогтоосон байна. Үндсэн Хуулийн Цэц энэхүү шийдвэрийг шалгаж байна.

Намууд

ГСДН: Холбооны улсын төвшинд сонгуулийг шинээр явуулах шийдвэр гарахтай цуг Холбооны Канцлер бөгөөд ГСДН-ын дарга, муж улсын сонгуулиудад ГСДН-ын авах санал байнга унаж буйд дүгнэлт хийсэн байна. 2004 оны эхний хагас жилд Бавари, Хамбург, Тюрингений сонгуулиуд ГСДН-ын хувьд сэтгэл түгшээсэн хэлбэртэй байсан бол харин үүний дараагийн сонгуулиуд ялагдлаар үргэлжилж байлаа. 2004 оны 9 дүгээр сарын 5-нд Заарландад ГСДН 30,8%-ийн санал авч, өмнөх сонгуультай харьцуулахад 14,7%-иар буурсан бол 9 дүгээр сарын 19-нд Бранденбургт 31,9%-ийн санал авч, 7,4%-иар буурсан байна. Мөн тэр өдөр Саксоны сонгуульд 9,8%-ийн санал авч (-0,9%), Германы Үндэсний намын дөнгөж өмнө нь орсоноор ГСДН-ын түүхэнд анх удаа хамгийн доод үзүүлэлтийг ийнхүү авчээ. 2005 оны 2 дугаар сарын 20-нд Шлесвиг-Хольштайнд ГСДН нь 38,7%-ийн санал авч (-4,4%), эрх барих үүргийг ХАХ-д алдсан ба харин Саксонд ХАХ-той их эвслийг үүсгэж, Засгийн газарт багтсан байна. 5 дугаар сарын 22-нд Нордрайн Вестфаленд ГСДН 37,1%-ийн санал авч (-5,7%), 39 жилийн дараа ийнхүү эрх барих хүчин солигдохыг тэвчин өнгөрүүлэх ёстой болжээ. Ийнхүү ГСДН Германы 16 муж улсаас зөвхөн 5-д нь л улс төрийн тэргүүлэх хүчин болж үлдсэн байв. 2004 онд ГСДН 30.000 гишүүнээ алдаж, 2005 оны

хавар гэхэд сүүлийн 50 жилд анх удаа гишүүдийн тоо 600.000-ын босгоос доош буусан байлаа.

Нэг талаас ГСДН сонгуульд ялагддаг гэсэн сэтгэгдэл бий болж, нөгөө талаас Хартц IV-ийг хэрэгжүүлэх явцад Үйлдвэрчний эвлэлтэй сөргөлдөж, түнжин хагарах аюул заналхийлж, мөн зүүний шинэ нам болох ВАСГ (Сонгуулийн Ажил, нийгмийн шударга ёс) байгуулагдсан энэ үед намын бодлого чиглэлийг өөрчлөхийг шаардсан дуу хоолой намын дотоодод улам чанга болж байлаа. 2005 оны 4 дүгээр сарын 12-нд намын дарга Франц-Мюнтеферинг намын хөтөлбөрийг шинэчлэх үндэслэлийг танилцуулахдаа, капиталын хүч олон улсад өссөн нэмэгдэж буйг анхааруулж, капитализмыг шүүмжилсэн яриа хэлэлцүүлгийг эхлүүлж байсан бол харин дараа нь Нордрайн-Вестфалений сонгуулийн үеэр зүүний чиглэлд хувьсан өөрчлөгдөж буйд тэрээр ихээхэн гайхсан байна. Зарим тодорхой санхүүгийн компаниуд ашиг орлогыг дээд хэмжээнд хүртэл нэмэгдүүлэх стратегиа олон улсын төвшинд хүчлэн тулгахдаа ардчиллыг сэвтээж буйг тэрээр мөн зэмлэн буруушаасан байна.

2005 оны 7 дугаар сарын 4-нд Намын бага хурлаас санал нэгтэй баталсан сонгуулийн хөтөлбөрт зүүний болон ажил эрхлэгчдийн жигүүрийн шаардлагыг тусгаж, Агенда 2010-ийг цааш үргэлжлүүлэхийн зэрэгцээ гэр бүлд чиглэсэн нийгмийн бодлогыг тэргүүн эгнээнд тавьсан.

ХАХ/ХНХ: 2004 оны 9 дүгээр сарын 19-нд Бранденбург, Саксонд болсон муж улсын сонгуулиудад ГСДН-аас гадна ХАХ ч авсан саналыг (-7,1% ба -15,8%) хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй болсон. 2 дугаар сарын 20-нд Шлесвиг-Хольштайны сонгуульд тус намын авсан саналын хувьд байдал ихээхэн өөрчлөгдсөн бол (+5,0%), харин 5-р сарын 22-нд Нордрайн-Вестфалены сонгуулиар байдал ашигтай болж (+7,8%), тухайн муж улсуудад тус нам 40,2%, 44,8%-ийн саналаар Засгийн газар эрх барих хүчин болжээ. Тус намаар толгойлуулсан сөрөг хүчин өдгөө Бундесратад 69 саналын 43-ийг буюу гуравны хоёрт дөхөж ирсэн байв. ХАХ, ХНХ нь 2005 оны 7 дугаар сарын 11-нд нэгдсэн сонгуулийн хөтөлбөрөө танилцуулсан байна. Хөтөлбөрийн гол цөм нь ажилгүйчүүдийн даатгалд төлөх хувийг 6,5-иас 4,5% болгож бууруулснаар ажлын

зардлыг бууруулахад оршиж байлаа. НӨТ-ийг 16-иас 18% болгож нэмэгдүүлснээр үүний зөрүү санхүүжилтийг нөхөх болжээ.

Хессен муж улсын ХАХ намын шүүхийн шийдвэрийн дагуу Мартин Хоф мангыг 2004 оны 7 дугаар сарын 20-нд намаас хөөсөн. Фулдын Бундестагийн гишүүн 2003 оны Германы нэгдлийн өдөрт жүүдийн эсрэг аястай үг хэлж, хэрүүл шуугиан гаргасан ажээ.

Холбоо 30/Ногооны нам: Улаан-ногооны намын нийгмийн шинэчлэлээс хаа сайгүй татгалзаж байсан ч энэ нь тус намд муж улсын сонгуулиудын үеэр сөрөг нөлөө үзүүлээгүй бөгөөд харин ч ГСДН-ны золионд илүү олон санал авсан. Хоёрдугаар сард Шлесвиг-Хольштайны сонгуульд 2000 оны нэгэн адил 6,2%-ийн санал авсан бөгөөд тавдугаар сард Нордрейн-Вестфаленд мөн урьдын төвшинг бараг (-0,9%) хадгалсан байна.

Бундестагийн шинэ сонгуульд улаан-ногооны нэгдсэн сонгуулийн хөтөлбөр баримтлахаас ногоонууд зай барьсан. Үүний дагуу эдийн засаг, хөдөлмөрийн зах зээлийн болон нийгмийн бодлогод голлон анхаарч, дундаж давхаргыг дэмжих, "хаягдсан давхаргын" нийгмийн байдлыг баталгаажуулахад чиглэсэн сонгуулийн хөтөлбөрөө 2005 оны 7 дугаар сарын 9/10-нд Берлинд болсон намын хурлаар баталснаар энэ нам ГСДН-аас сонгуулийн хөтөлбөрөө тусгаарласан байна. Гадаад хэргийн сайд Йошка Фишерийг нэр дэвшигчээр сонгуульд уралдуулахаар намын хурлаас шийдвэрлэжээ.

Германы Үндэсний Нам (ГҮН): 2004 оны 9 дүгээр сарын 12-нд Саксоны сонгуульд тус нам 9,2%-ийн санал авч, муж улсын сонгуульд амжилт гаргасан нь Герман даяар анхаарал татсан бөгөөд Шлесвиг-Хольштайн, Нордрейн Вестфалений сонгуулиудад барууны радикал нам 1,9%, 0,9%-ийн саналыг тус тус авч бараг ач холбогдолгүй шахам үлдсэнээр олны дунд үүссэн айдас болгоомжлолыг дарж өгсөн байна. Холбооны Дотоод Хэргийн сайдын Үндсэн хуулийг хэрхэн хамгаалсан тухай тайлан мэдээнд 2004 онд барууны намын 24.000 гишүүн байснаас 5300 нь ГҮН-ын гишүүн байжээ.

Зүүний намууд: Саксон (23,6%), Бранденбург (28%-ийн муж улсын сонгуулийн дүнгээс харахад ГСН нь Зүүн Германы муж улсуудад хоёр дахь чухал улс төрийн хүчин болохыг нотолж байна.

Харин Шлесвиг-Хольштайн (0,8%), Нордрайн-Вестфален (0,9%)–д болсон сонгуулиас үзэхэд Германы баруун хэсэгт энэ нам урьдын адил нэр нөлөө багатай хэвээр байв. Бундестагийн сонгуулийг урагшлуулах болсон нь ВАСГ хэмээх намыг богино хугацааны дотор байгуулахад ихээхэн түлхэц үзүүлсэн байна. ГСДН–аас салсан хэсэг хүмүүс болон үйлдвэрчний эвлэлийнхэн санаачлан 2005 оны 1 дүгээр сарын 22–нд Геттингенд тус намыг үүсгэн байгуулсан бөгөөд чингэхдээ зүүний сөрөг хүчин болох зорилгыг агуулж байжээ. Энэ нам нь 2005 оны 5 дугаар сарын 22–нд Нордрайн–Вестфалены муж улсын сонгуульд анх удаа оролцож, 2,2%–ийн санал авсан байна.

ВАСГ–д эерэг нөлөө үзүүлж, тус намыг барууныханд илүүтэй хүлээн зөвшөөрүүлэхийн тулд ГСН “Зүүний нам” гэсэн нэртэй байхыг зөвшөөрч, Бундестагийн сонгуульд дангаар оролцохоос татгалзаж, өөрийн сонгуулийн хуудсыг ВАСГ–ын нэр дэвшигчдэд мөн нээж өгсөн. 7 дугаар сарын 3–нд ВАСГ–ын Намын хурлаар хамтын ажиллагааг хүлээн зөвшөөрсөн ба ГСН–ын хувьд 7 дугаар сарын 17–нд Берлинд намынхаа хурлыг хийхээр шийдвэрлэсэн байна. 7 дугаар сарын эхээр болсон санал асуулгын дүнд Зүүний нам 11%–ийн дэмжсэн санал авч, Бундестагийн сонгуулийн үеэр амжилт гаргах төлөвтэй байсан нь нэртэй улс төрчид болох Грегор Гизи (ГСН), Оскар Лафонтайне нарын хамтын хүчин чармалтад ихээхэн тулгуурлаж байлаа.

Төсөв, санхүүгийн бодлого

Татварын шинэчлэл: 2005 оны 1 дүгээр сарын 1–нд улаан–ногоон намуудын Эвслийн Засгийн газраас хэрэгжүүлж буй татварын шинэчлэлийн гуравдугаар үе шат хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Үүний дүнд босго татвар 16–аас 15%, дээд татвар 45–аас 42% болж буурсан байна.

Татварын хяналт шалгалт: 2005 оны эхний улиралд татварын хяналт, шалгалтаар холбоо, муж улсууд, коммуунуудад 1,5 тэрбум орчим еврог оруулсан байна. 2004 оны 1 дүгээр сарын 1–нд шударга татварын хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээр гадаадад хууль бусаар хадгалагдаж байгаа 20 тэрбум еврог буцааж авчрахаас 5 тэрбум еврог улсын санхүүгийн кассанд хийхээр тооцоолж байгааг Холбооны Сангийн сайд мэдэгдсэн байна.

Холбооны төсөв 2004: Татварын орлого буурч, газрын тос, тамхины татвар 1,5 тэрбум евро болсон нь тооцож байснаас ихээхэн доогуур гарсан, ачааны машинаас хураамж авч арай эхлээгүй байсан зэргээс шалтгаалж Холбооны сангийн сайд Ханс Айхел 2004 оны 10 дугаар сарын 6-нд 2004 оны төсвийн тодотголыг танилцуулсан ажээ. Уг тодотголд 43,7 тэрбум еврогийн зээлийг цэврээр авахаар тусгасан нь шинэ рекорд тогтоосон төдийгүй, энэ нь өмнө тогтоосноос 14,2 тэрбум еврогоор илүү гарсан байна. Зээлийн хэмжээтэй цуг хөрөнгө сруулалтыг 19,1 тэрбум еврогосор нэмэгдүүлэх болсноор Үндсэн хуулийн 115 дугаар зүйлийн дагуу үндсэн хуулийн эрх зүйд нийцүүлж төсвийг хуульчлах нь тулд нийт эдийн засгийн тэнцвэртэй байдалд саад бэрхшээл учруулж байгааг Айхель тайлбарласан байна. Сөрөг хүчний фракцууд 12 дугаар сарын дундуур Холбооны 2004 оны төсвийн талаар Холбооны Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргасан.

Холбооны төсөв 2005: Айхель 2005 оны төсвийг Бундестаг танилцуулахдаа дотоодын эдийн засгийн байдал сул байгаа тул улсын төсвийг алдагдлыг хязгаарлахын тулд хэмнэлтийн шинэ арга хэмжээг авахаас татгалзсан байна. 2005 оны төсвийг 2004 оны 11 дүгээр сарын 26-нд Бундестаг баталсан.

Хөдөлмөр ба нийгмийн бодлого

Хөдөлмөрийн зах зээл дэх шинэчлэлт – “Хартц IV” - 2003 оны 3 дугаар сард Холбооны Канцлер Шрёдерийн зарласан шинэчлэлийн хөтөлбөр “Агенда 2010”-ийн хөдөлмөрийн зах зээлийн бодлогын тухай сүүлийн хэсэг болох “Хөдөлмөрийн зах зээлд үзүүлэх орчин үеийн үйлчилгээний дөрөвдүгээр хууль”-ийг удаан хугацаанд хэлэлцэн маргасны эцэст Бундесрат 2004 оны 7 дугаар сарын 9-нд баталсан билээ. Германы зүүн хэсгийн 4 муж улс эл хуулийг зөвшөөрөөгүй дахин бөгөөд ГСДН-ын толгойлсон 2 муж улс (Мекленбург-Порфоммерн ба Берлин) түтгэлзсэн санал өгсөн байна. “Хартц IV” товлосон хугацаанаас хагас жилээр хоцорч, 2005 оны 1 дүгээр сарын 1-нд хүчин төгөлдөр болсон. Дэмжинэ ч, шаардана ч гэсэн уриан дор юуны өмнө удаан хугацааны туршид ажилгүй байгсдыг хөдөлмөрийн зах зээлд буцааж оруулахад чиглэх ажээ. Тэдэнд зориулж ажилгүйчүүдийн тусламж болон нийгмийн

тусламжийг хамтатган ажилгүйчүүдийн мөнгө II (АЛГ II) гэж нэрлэхээр болгожээ. Үндсэн тэтгэмж хуучин муж улсуудад 345 евро, шинэ муж улсуудад 331 евро байх бөгөөд байрны хөлс, халаалтын мөнгийг өргүүлэн төлөх ажээ. АЛГ-II-ийг хүлээн авагчдаас ёс заншилд харш бус аливаа ажлыг хийхийг шаардах боломжтой бөгөөд тэд татгалзах алаас тэтгэмжийн хэмжээг бууруулна.

Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд эхний хагас жилд зохион байгуулалтын асуудлууд, захиргааны дутагдалтай талуудаас гадна бусад бэрхшээлүүд тохиолдож байсан бөгөөд үүнд:

- Удаан хугацааны туршид ажилгүй байгсдыг хөдөлмөрийн агентлаг, коммуны 356 нийгэмлэг, дангаараа хариуцлага хүлээх чадвар бүхий 69 сонголтот коммун, Холбооны хөдөлмөрийн агентлагийн 19 депендансад тус тус хуваасан нь тооцоолж байсан шиг тийм үр ашигт ихэвчлэн хүргэсэнгүй.
- Коммунууд өнөөг хүртэл өөрсдийн дэмжсээр ирсэн нийгмийн тусламж хүртэгсдийг Хөдөлмөрийн агентлагаас санхүүждэг АЛГ-II-ийг хүртэгсэд болгох боломжийг тооцоноос хэд дахин илүү ашигласан байна.
- Үйлчлүүлэгчдийн нийгмийн бүтцийн талаарх статистик таамаглал зарим чухал асуудлын хувьд буруу байсан нь илэрсэн: Өргөдөл гаргасан дөрвөн хүн тутмын нэг нь АЛГ II-оос татгалзахын оронд (учир нь тэд өөрийн хөрөнгөөс хэрэглэхэд голлон анхаарч байв) харин долоон хүн тутмын нэг нь л татгалзаж байсан.
- Хөдөлмөрийн зах зээлд ажилгүйчүүдэд зуучлах ачаалал буурахгүй байснаар (2005 оны нэгдүгээр улиралд ажилгүйчүүдийн тоо 5,14 сая) АЛГ II-ийг хүлээн авагчдын тоо 2005 оны хавар гэхэд Засгийн газрын зүгээс 2004 оны 6 дугаар сард хийсэн тооцооноос 800.000 хүнээр илүү гарсан байна. 2005 онд Хартц IV цогцолбор хөтөлбөрт бүтэн жилийн туршид зарцуулахаар төсөвлөсөн 14 тэрбум евро эхний улирлын тооцоогоор 23,6 тэрбум евро болж өсөх төлөвтэй байна.

- Нийгмийн өршөөлгүй, хатуу байдал, шинэчлэлийн тэнцвэргүй байдал өөрөөр хэлбэл хөдөлмөрийн зах зээлд ажил олж хийх бараг боломжгүй тийм хүмүүсийг л шинэчлэл юуны өмнө хамарч байсан нь олонхи хүмүүсийн урмыг хугалж байв. Хууль гарсны дараа 2004 оны 8, 9 дүгээр сард Хартц IV-ийг эсэргүүцсэн “Даваа гаригийн жагсаал” хэд хэдэн хотуудад зохиогдож, зарим үед 40.000 хүн оролцсон байна.

Хартц IV-ийн талаар ирсэн гомдлыг хүлээн авах газар болон Омбудын зөвлөлөөс гаргасан зөвлөмжинд тулгуурлан Эдийн засаг, хөдөлмөрийн сайд Вольфганг Клемент 2005 оны 6 дугаар сарын эцсээр Хартц IV хөтөлбөрт хэд хэдэн засвар оруулах болсон тухай мэдэгдсэн. Ялангуяа Зүүн Германы АЛГ II-ийг Баруун Германы төвшинтэй адилтгах хэрэгтэй байсан бөгөөд үүний эхний арга хэмжээ болгож, Бундесрат удаан хугацааны ажилгүйчүүдэд ойр зуурын орлого олох боломжийг нэмэгдүүлэхийг 7 дугаар сарын 8-нд зөвшөөрсөн байна.

Агенда 2010 хөтөлбөрийн хүрээнд хэдийнээ эхлүүлсэн ба 2003 оны эцсээр хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн хөдөлмөрийн зах зээлийн шинэчлэлтийн бусад хэсгүүдэд (Хартц I-ээс Хартц III хүртэл) ч мөн хэрэгжүүлэх явцад асуудал тулгарч, үр ашиггүй байдал буюу тооцоологдоогүй нэмэлт зардал зэрэг гарсан байна.

Ажил хөдөлмөр эрхлэх бүх төрлийн боломжийг олжилруулэх, илүү олон хүнийг бүрэн үнэ цэнэтэй буюу байнгын ажилтай болоход нь туслах найдвар зөвхөн бага хэмжээгээр биеллээ олсон нь хөдөлмөр зуучлалыг шинэ хэлбэрээр зохион байгуулах болсон, ажилгүйчүүдэд ирэх дарамт ихэссэн зэрэгтэй холбоотой байв. Дэмжлэг үзүүлсэн жижиг-ажлын байрны тоо 2004 оны эцэс 4,9 саяд хүрч, урьд жилтэй харьцуулахад 350.000-аар нэмэгдсэн байна. Энэ нь хагас болон бүтэн цагийн нилээд ажлын байрыг шахсан тул нийт ажил эрхлэлт бараг нэмэгдсэнгүй. Би-ХК-ийг байгуулах ажил амжилттай явагдаж, амьжиргаагаа авч явах аргыг бий болгоход зориулсан тусламжийг 2005 оны дунд үе хүртэл 236.000 хүн авч хэрэглэсэн бөгөөд дэмжлэг хүртэгсдийн бараг тал хувь нь ажилгүйчүүдийн эгнээнд буцан орсон байна. Үүний зэрэгцээ хөдөлмөрийн зах зээлд чиглэсэн бодлогын энэ хэсгийг хэрэгжүүлэх зардлыг 2005 онд хоёр дахин нэмэгдүүлж,

1,45 тэрбум еврод хүргэжээ. Энэ хөрөнгө мөнгийг буруугаар ашиглах явдал гаргуулахгүйн тулд Парламент 2004 оны 9 дүгээр сарын 29/10 дугаар сарын 15-нд дэмжлэг үзүүлэх урьдчилсан нөхцлүүдийг нилээд хатуу байхаар шийдвэрлэсэн бөгөөд энэ нь 2005 оны эхээр үйлчилж эхэлсэн байна. Боловсон хүчинд үйлчилгээ үзүүлэх 850 агентлагийг байгуулсан нь бүтэл муутай болсон гэж дүгнэсний хойно ажилд зуучлахад төвөгтэй хүмүүс буюу уран бүтээлчдийг ажилд оруулж, Холбооны Хөдөлмөрийн Агентлагаас хамтран санхүүжүүлж байна. 2003 онсос хойш иймэрхүү аргаар 25.000 хүн ажилтай болсон байна. Энэхүү төсөлд гаргасан зардал 580 тэрбум еврод хүрсэн байна.

Асрамж, эрүүл мэнд, тэтгэврийн шинэчлэл: Хүүхэдгүй хүмүүст зориулсан асрамжийн даатгалын хураамжийг нийт цалингийн 0,25%-иар нэмэгдүүлэхийг Бундесрат эсэргүүцэж гомдол гаргасан бөгөөд 2004 оны 11 дүгээр сарын 26-нд Бундестаг Канцлерийн хамт олонх болж уг гомдлыг буцаасан байна. Ийнхүү хууль тогтоогчид гэр бүл дэх асрамжийн даатгалын байдлыг сайжруулах тухай Холбооны Үндсэн хуулийн цэцийн үүрэг даалгаврыг биелүүлжээ. Асрамжийн даатгалын хураамжийн өсөлт нь хүүхэдгүй бөгөөд хөдөлмөр эрхэлдэг, 23-аас дээш насны хүмүүст 2005 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Харин үүнд 1940 оноос өмнө төрсөн бөгөөд АЛГ II-ийг хүртдэг даатгуулагчид хамаарахгүй ажээ.

Хиймэл шүд ба өвчтэй үед олгох мөнгөнд тусгай хураамж тогтоох явдлыг Бундесрат болон сөрөг хүчнийхний эсэргүүцлийг үл харгалзан 2004 оны 11 дүгээр сарын 5-нд Бундестаг 2005 оны 7 дугаар сарын 1-нээс хүчин төгөлдөр үйлчлэхээр баталсан байна.

2004 оны 6 дугаар сарын 16-нд Бундестагийн баталсан тэтгэврийн удаан хадгалагдах хууль 2005 оны эхнээс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Тэтгэвэр авагчдын тоо нэмэгдвэл жилийн тэтгэврийн нэмэгдлийг бууруулах бөгөөд хэрвээ татвар төлөгчдийн тоо нэмэгдвэл жилийн тэтгэврийн хэмжээ нэмэгдэж байх тухай дээр хуулинд заажээ. Жирийн тэтгэвэр авагчийн тэтгэврийн цэвэр хэмжээ жилийн нийт орлогын дундажийн 46%-иас доошгүй байх ёстой. 2004 онд энэ нь 53% буюу 30.000 орчим евро байна.

2003 оны 3 дугаар сард Холбооны Үндсэн Хуулийн Цэцээс шаардсаны дагуу тэтгэврийнхэн болон албан хаагчдыг нэгдсэн татварт хамруулах тухай настай хүмүүсийн орлогын хууль нь 2005 оны 1 дүгээр сарын 1-нд хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. 2040 он хүртэл тэтгэврийн хүмүүсийн татвар чангарах бөгөөд харин тэтгэврийн хууль ёсны даатгал хэд хэдэн үе шаттайгаар татвараас чөлөөлөгдөх ажээ. 2040 оноос эхлэн чөлөөт тэтгэмжээс бусад бүх төрлийн настайчуудын тэтгэвэр, тэтгэмжинд татвар ногдуулна.

Гадаад иргэдийн талаар явуулах бодлого: 2005 оны 1 дүгээр сарын 1-нд Цагаачлалын болон Интеграцийн хууль үйлчилж эхэлсэн. Дөрвөн жилийн туршид дотооддоо маргалдан хэлэлцсэний эцэст 2004 оны 7 дугаар сард зөвшөөрөгдсөн байна. Энэ хууль нь гадаад хүмүүс тус улсад ирэх, оршин байх, нийгмийн нэг бүрэлдэхүүн хэсэг болох асуудлыг зохицуулж, тэдний дотоод аюулгүй байдалд халдахаас хамгаалах журмуудыг агуулсан байдаг.

“Гар гараасаа барилцан энх тайвны төлөө, аллага хядлагын эсрэг” гэсэн уриандор Кельн хотод 2004 оны 11 дүгээр сарын 21-нд мусламчууд голцуу 25.000 хүн исламын терроризмоос татгалзаж жагсаал хийсэн байна. Үүний үр дүнд Турк-Исламын холбоог байгуулсан бөгөөд энэ нь Герман дахь туркуудын хамгийн чухал шашны нэгдэл юм.

Хүрээлэн буй орчин, зам тээврийн талаар авч хэрэгжүүлсэн бодлого

Уур амьсгал хамгаалал: Киото-гийн Протоколд заасан үүргүүдийг хэрэгжүүлэхийн тулд Герман нь 2012 он хүртэл агаар дахь хорт хийн ялгаруулалтыг 21%-иар (1990 оны төвшинтэй харьцуулахад) бууруулах бөгөөд 2005 оны эхээр хорт хийн сертификатуудыг худалдаалах тухай Европын Холбооны нэгдсэн журмыг мөрдөх болжээ. Европын Холбооны дүрэм журмын дагуу Германы компаниуд ирэх 3 жилд нийт 1485 сая тонн нүүрс хүчлийн хий (жил бүр 495 сая тонн нүүрс хүчлийн хий)-г ялгаруулж болно. Энэхүү хэмжээ нь хорт хийн эрхийн сертификатуудтай тохирч байх бөгөөд уг сертификатыг Холбооны байгаль орчны албаны хорт хийн худалдааны асуудал эрхлэх газраас хуваарилан тараах төлөвлөгөөний дагуу оногдсон 1849 байгууламжинд тараасан.

Гентехникийн хуулиуд: 2005 оны 2 дугаар сарын 3-нд Канцлерийн дэмжлэгийг авсан Гентехникийн хууль үйлчилж эхэлсэн. Европын Холбооны дүрэм журмуудыг хэрэгжүүлснээр энэ нь уламжлалт ашигт ургамлууд болон гентехникийн тусламжтайгаар өөрчлөгдсөн ургамлуудыг хөдөө аж ахуйд хэрхэн уялдуулах асуудлыг зохицуулж байна. Үүнд, хамгийн гол асуудал нь хэрвээ гентехникийн аргаар хөршийнхөө газрыг бохирдуулсан эс бөгөөс хохирол учруулсан тохиолдолд хохирол учруулагчийн зарчмыг нэатрүүлэх тухай эл маргаантай асуудал юм.

Эвсэл болон ХАХ/ХНХ-ны фракцын хамтран гаргасан Биопатентын хууль нь 2005 оны 2 дугаар сарын 28-нд хүчин төгөлдөр болсон. Энэхүү хуулиар хүний гентэй холбогдох өвчтөний эрхийг хязгаарлаж, хүний бие организмыг эсийн аргаар хувилахыг өвчтөнд хориглосны зэрэгцээ хүний үр хөврөлийг худалдаа болон үйлдвэрт ашиглахыг хориглосон байна.

Нарийн тоосонцрын дарамт: Агаарыг цэвэр тунгалаг байлгах талаар авах арга хэмжээ хоцорч буйн улмаас Штуттгарт хотын 2 иргэн гомдол гаргасны мөрөөр Баден-Вюртемберг муж улсад үйл ажиллагааны хөтөлбөр байгуулж ажиллахыг 2005 оны 5 дугаар сарын 31-нд Штуттгарт хотын Захиргааны шүүхээс даалгасан байна. 3 дугаар сарын 13-нд Штуттгарт хотноо нарийн тоосонцрын хэмжээ 36 дахь удаагаа тогтоосон хэмжээнээс хэтэрсэн бөгөөд тухайн жилийн эхнээс мөрдөгдөж эхэлсэн Европын Холбооны журмын дагуу (1 куб метр агаарт байх тоосонцорын хэмжээ 50 микрограммаас хэтрэх ёсгүй) жилийн туршид энэ хэмжээ хамгийн олондоо 35 удаа хэтэрч болох ажээ. Энэ талаар түүнтэй ойролцоо бусад хотуудад тухайлбал, Мюнхень, Дюссельдорф, Берлинд мөн иргэд шүүхэд гомдол мэдүүлсэн байна.

Ачааны машины хураамж: Холбооны бараа тээврийн газар хиймэл дагуулд тулгуурласан хураамжийн системийг ажиллуулах түр зөвшөөрлийг 2004 оны 12 дугаар сарын 15-нд авсан. Анх тогтоосон хугацааг 3 удаа хойшлуулж, 16 сар хожимдуулсны эцэст 2005 оны 1 дүгээр сарын 1-нд техникийн хувьд багасгасан хувилбарыг хэрэгжүүлж эхэлсэн. Гүйцэтгэгч консорциум болох Toll Collect гэрээнд тусгагдсан системд шаардагдах зүйлсийг 2006 оны

эхэн үеэс гүйцэтгэж эхэлнэ. Зөвшөөрөгдсөн нийт жин нь 12 тонноос илүү гадаад, дотоодын ачааны машинд холбооны авто замаар явахад замын уртаас хамаарал бүхий хураамж үйлчилж байна. Машины овор хэмжээ, тэнхлэгийн тооноос хамаарч, километр бүрт 9-14 сентын хураамжтай. Холбоо нь 2005 онд ачааны машинаас нийт 3 тэрбум еврогийн орлого авахаар тооцож байсан. Үйлдвэрлэлийн зардлыг хасаад зам тээврийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтанд нийт 2,4 тэрбум евро үлдэж байна. Үүнээс 1.2 тэрбум еврог Холбооны хслын зайн замуудад, 910 сая еврог төмөр замд, 290 сая еврог усан замын тээвэрт хөрөнгө оруулах болно.

Дотоодын аюулгүй байдал, алан хядагчдаас хамгаалах асуудал

Аюул заналын байдал: Үндсэн хуулийг хамгаалах тухай 2004 оны тайланг танилцуулах үеэр Холбооны Дотоод Хэргийн сайд Отто Шили (ГСДН) исламын терроризм Германы дотоодын аюулгүй байдалд цаашид ч мөн хамгийн том аюул занал хэвээр байна хэмээн 2005 оны 5 дугаар сарын 17-нд Берлинд мэдэгдсэн байна. Өдгөө Холбооны нутаг дэвсгэрт ийм уг үндэс бүхий 171 хэрэг гарсан байна. 2004 онд гадаадын экстремист үзэлтнүүд 461 гэмт хэргийг үйлдсэн бөгөөд үүнээс 61 хүч хэрэглэсэн гэмт хэрэг бүртгэгджээ (2003 онд 1473 ба 88). Исламын байгууллагуудын гишүүд, дэмжигчдийн тоо 1000-аар өсч, 318.000-д хүрсэн бөгөөд энэ нь Германд амьдарч буй мусламуудын бараг 1 орчим хувьтай тэнцэж байна.

Алан хядагчдын эсрэг авсан арга хэмжээ: 2004 оны 7 дугаар сарын 7-нд холбоо ба муж улсуудын дотоод хэргийн сайд нарын бага хурал дээр исламын терроризмтой тэмцэхдээ нэгдсэн төв мэдээллийн баазтай болох асуудалд санал нэгдсэн. Исламуудын файл буюу тодруулбал алан хядагчдын эсрэг файлыг Үндсэн хуулийн хамгаалах холбооны албанд байгуулж, улмаар цагдаа, холбооны тагнуулын алба, Үндсэн хуулийг хамгаалах албадад буй исламын экстремизмын талаарх мэдээллийг нэгтгэж, бэлтгэх болно. Мэдээллийг хамгаалах асуудал эргэлзээтэй байсан тул Бундестаг нь Засгийн газрын эвсэл болон ГЧН-ын дэмжлэгтэйгээр Бундесратын гаргасан хуулийн төсөлд татгалзсан хариу өгсөн.

2001 онд гаргасан Терроризмын эсрэг хуулийн дагуу хийсэн шалгалтын тайланг Дотоод Хэргийн сайд Шили 2005 оны 5 дугаар сарын 11-нд Холбооны Засгийн газарт танилцуулсан. Хатуу хянуулсан улс болчих вий гэж шүүмжлэгчид болгоомжилж байсан ч гийм байдалд орсонгүй. 2007 он хүртэл үргэлжлэх хуулийн хүчинтэй хугацааг хугацаагүйгээр сунгах, үүнээс гадна алан хядагчдаас хамгаалах гурав дахь багц арга хэмжээг оруулах санал санаачлага буйг Шили мэдэгдсэн байна.

Сайтар тунгаан бодсоны дараа Холбооны Ерөнхийлөгч Көзлер 2005 оны 1 дүгээр сарын 12-нд Агаарын аюулгүй байдлын хуулинд гарын үсэг зурсан. Уг хуулиар хэрвээ зорчигч тээвэрлэсэн онгоцыг алан хядагчид барьцаалж, зэвсэг болгон хэрэглэх гэж буй үед өөр аргагүй тохиолдолд тэрхүү онгоцыг устгах тушаал өгөх бүрэн эрхийг Холбооны Батлан хамгааллын сайдад олгосон байна. Энэ хуулийг Бундесрат эсэргүүцэж, гомдол гаргасан боловч 2004 оны 9 дүгээр сарын 24-нд Бундестаг Канцлерын дэмжлэгтэйгээр олонх болж хуулийг баталсан. Терроризмоос хамгаалах үйл хэрэгт Холбооны Зэвсэгт хүчин оролцох хууль ёсны эрхийг олгохын тулд Үндсэн хуулинд өөрчлөлт оруулах ёстой гэж сөрөг хүчин үзэж байв. Энэхүү хуулийг хүчин төгөлдөр болсноос хойш Холбооны Үндсэн Хуулийн Цэцэд хэд хэдэн субъектээс гомдол мэдүүлсэн байна.

Гадаадад аялах паспорт: Биометрийн шинж тэмдгийг тусгасан шинэ аялалын паспортыг нэвтрүүлэх тухай Холбооны Засгийн газрын журмыг Бундесрат 2005 оны 7 дугаар сарын 8-нд зөвшөөрсөн. Харин энэ асуудлыг Бундестаг 2002 оны 1 дүгээр сард Терроризмтэй тэмцэх хуулийн хамтаар баталсан. Иргэдэд 59 еврогийн үнэ өртөгтэйгээр очих эл бичиг баримтыг 2005 оны 11 дүгээр сарын 1-нд гадуур тарааж эхэлсэн. Ийнхүү паспортад биометрийн мэдээллийг оруулснаар аялалын зам, сүлжээний аюулгүй байдлыг илүүтэй хангах тухай олон улсын тохиролцоог биелүүлж чадсан байна. Мэдээллийг хамгаалах асуудлыг хариуцсан ажилтны сануулж хэлсэнчлэн техникийн эрсдэлийг хангалттай хэмжээгээр шалгаагүй ажээ.

Исламын терроризмын хэргүүд: 2001 оны 9 дүгээр сарын 11-нд АНУ-д болсон террорист халдлагад тусалсны улмаас Моунир

ал-Мотассадек хэмээх Марокка улсын иргэний хэргийг Хамбург хотын Ханзетийн Дээд шүүхээс 2004 оны 8 дугаар сарын 10-нд дахин шалгаж, хянасан байна. Түүний нутаг нэгтэн Абделгхани Мзоуди-гийн мөн адил хэргийг цагаатгасныг Хамбургийн шүүх 2005 оны 6 дугаар сарын 9-нд эцэслэн нотолсон байхад харин Холбооны өмгөөлөгчийн хянасан шийдвэрийг Холбооны шүүх няцаасан байна. Мзоудий 2005 оны 6 дугаар сарын 20-нд нутагтаа буцсан.

Барууны терроризмын хэрэг: Пстсдам дахь Бранденбургийн шүүх 12 залууд террорист бүлэглэлд нэгдсэнийнх нь улмаас 2005 оны 3 дугаар сарын 7-нд шийтгэл оноосон. Толгойлогчдод нь 4,5 жилийн хорих ял, бусдад нь Залуучуудын эрүүгийн хуулийн дагуу 8-24 сарын тэнсэнгийн ял оноосон байна. Тэд хэт барууны бүлэг "Frei-corps"-ийг байгуулж, цагаачлан ирэгсдийн аж ахуйд тоо тоомшгүй олон гал түймэр тавьжээ.

Нууцаар чагнах тухай: Засгийн газрыг бүрдүүлж буй эвсэл болон холбооны намууд нууцаар чагнах тухай журмыг дахин шинэчлэх асуудалд санал нэгдсэний хойно 2005 оны 6 дугаар сарын дундуур Парламентын хоёр танхим хуулийн нэмэлт өөрчлөлтийг зөвшөөрсөн. Ингэснээр мөрдөн байцаагчид зохион байгуулалттай болон хүнд гэмт хэргийг мөрдөхөд ажлын байр болон орон гэрийг цаашид акустикийн аргаар хянаж чадах болсон. Ингэж чагнахыг зөвшөөрдөг гэмт хэргийн төрлийг нэмэгдүүлж, бүлэг сексийн хүнд гэмт хэргийг хамруулах болжээ. Хэрвээ хувийн амьдралын жирийн хүрээг чагнаж эхэлбэл чагнах аппарат даруй унтарна.

Цуглаан хийх эрх: Парламентын хоёр танхим 2005 оны 3 дугаар сарын 18-нд цуглаан хийх эрхийг шинээр баталсан бөгөөд ингэснээр энэ нь 4 дүгээр сарын 1-нд буюу товлосон хугацаанд Дэлхийн хоёрдугаар дайны төгсгөлийг дурсан санах өдрийн өмнөхөн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Хэрвээ националь-социалистуудын гарт хэлмэгдэн золиослогдосдын дурсгалд хохирол учруулах тохиолдолд урьдын хорих лагериуд зэрэг түүхэн чухал сургамж авах газруудад цуглаан хийхийг хориглож болно. Үүнд Еврейчүүдийг хомроглон устгасныг дурссан Берлин дэх харууслын хөшөөг хуульд дурдсан байна. Муж улсууд цаашид хамгаалах газруудыг хуулиндаа зааж болно.

Боловсрол, соёлын бодлого

Соёлын байгууллагуудын хүнд суртал: Нийдерсаксоны муж улсын Засгийн газар 2005 оны эцсээр Соёлын сайд нарын бага хурал (КМК)-ын гэрээг хүчингүй болгох шийдвэрийг 2004 оны 10 дугаар сарын 5-нд гаргасан. КМК нь Холбооны муж улсуудын нэгдсэн байгууллага болохын хувьд Германы боловсрол, соёлын бодлогын төв зөвлөл нь юм. Ийнхүү нэг түнш нь гарснаар КМК бүхэлдээ орших бараг үндэслэлгүй болсон. Энэхүү алхмыг Ерөнхий сайд Кристиан Вульф (ХАХ) шинэчлэлийг хэрэгжүүлж эхлэхийн тулд санаачилжээ. КМК хэтэрхий үнэтэй байна, хэтэрхий хүнд сурталтай байна, хэтэрхий бага шинэчлэгдэж байна гэж үзсэн ажээ. Ерөнхий сайд нарын бага хурал КМК-ийн зардлыг эрс бууруулах тухай шийдвэрийг 12 дугаар сарын 15/16-нд гаргасан. Ийнхүү КМК-ийн гэрээг хүчингүй болгох явдал Нийдерсаксоны тусламжтайгаар бодитоор биелжээ.

Ихээхэн маргаантай зөв бичих дүрмийн шинэчлэлтийн ихэнх хэсэг 2005 оны 8 дугаар сарын 1-нд хүчинтэй болох шийдвэрийг Ерөнхий сайд нарын бага хурал 2004 оны 10 дугаар сарын 8-нд гаргасан. Гэвч энэ асуудалд Бавари, Нордрайн-Вестфален муж улсууд 7 дугаар сарын дунд үеэс хойш татгалзах болжээ.

2005 оны 5 дугаар сарын 10-нд Берлинд “Европт алагдсан еврей нарт зориулсан хөшөө” (Holocaust-Mahnmal)-ний нээлтийг баяр ёслолын байдалтай хийсэн. Сангийн Удирдах Зөвлөлийн дарга бөгөөд Холбооны Бундестагийн Ерөнхийлөгч Вольфганг Тийрзе (ГСДН) нээлтийн үгийг хэлэхдээ, уран барималч Петер Айзенманы урласан хөшөө нь Германы нийслэл хотын төвд аймшигтай гэмт хэргийн ой тоонд багтамгүй байдлыг илтгэсэн үндэсний бэлэг тэмдэг хэмээн тодорхойлжээ.

Их, дээд сургуулиуд: Холбооны намуудын дэмжлэгтэйгээр батлагдаж, 2004 оны 9 дүгээр сарын эхээр хүчинтэй болсон Их, дээд сургуулийн суурь хуулинд оруулсан өөрчлөлт нь их, дээд сургуулиудын бие даасан байдлыг нэмэгдүүлсэн. Хязгаарлагдмал тоогоор оюутан элсүүлдэг салбаруудад шинээр элсэн суралцах оюутнуудынхаа 60%-ийг сургуулиуд өөрсдөө сонгоно. Үлдсэн

40%-ийг оюутны орон тоог хуваарилах Дортмундын төв газраар дамжуулж, улсын шалгалтын онооны дүн (20%), хүлээх нэрсийн жагсаалт (20%)-ын дагуу хуваарилна.

2002 онд Их, дээд сургуулийн суурь хуулинд их, дээд сургуульд анх удаа суралцаж буй тохиолдолд хураамжаас чөлөөлөх тухай заалтыг хүчингүй болгуулах хүсэлтийг холбоодын намын удирддаг холбооны зургаан муж улс 2005 оны 1 дүгээр сарын 26-нд зөвшөөрсөн байна.

Дуулиант хэргүүд

ХАХ-ын хар мөнгөний дуулиант хэрэг: Холбооны Бундестагийн Ерөнхийлөгч Вольфганг Тийрзе 2000 онд ХАХ намын эсрэг хориг тавьж, 21,1 сая еврог улсын хандивын сангаас Бундестагийн захиргаанд буцааж төлөхийг шаардсаныг 2004 оны 9 дүгээр сарын 16-нд Холбооны Үндсэн Хуулийн Цэцээс бататгасан байна. Ийнхүү шаардах болсны үндэслэл нь Хессены муж улсын холбоо нь 1998 оны тайландаа 9 сая илүү еврог тайлбарлалгүй орхиж, хуулинд харшилсан явдал байв. Хар кассыг илрүүлсэнээр 2000 оны эхээр скандал дэгдсэн юм.

Энэ хэрэгт холбогдуулан Вийзбадены мужийн шүүх 2005 оны 4 дугаар сарын 18-нд Холбооны Дотоод Хэргийн сайд асан Кантер-т үнэнч бус байж, ХАХ намыг төлбөрт унагасны нь төлөө 18 сарын тэнсэн ял, 25.000 еврогийн торгуулийг шийтгэл болгон оноосон.

ХАХ намын санхүүгийн зөвлөх асан Хорст Вэйрайхийг үнэнч буй үйлдэл хийхэд нь дэмжиж, тэтгэсний нь төлөө 61.200 еврогийн торгууль ногдуулсан байна.

Бундестагийн Ерөнхийлөгч 2004 оны 12 дугаар сарын 22-нд ХАХ намын хууль бус санхүүжилт явуулсны нь төлөө 511.000 сая еврогийн торгуулийн төлбөрийг ХАХ нам цаашид төлөх болсныг олон нийтэд мэдэгдсэн. 1990-ээд онд Хессений муж улсын холбоо нь амттан үйлдвэрлэдэг Феррерогоос хэд хэдэн удаагийн их хэмжээний хандив авч, үүнийг тайлан тооцоондоо тусгаагүй байсан ажээ.

Визийн дуулиант хэрэг: Зүүн Европын орнуудаас Германд зочлох урилгыг бөөн бөөнөөрөө гэмт үйлдэлдээ ашиглахад нь Холбооны Засгийн газар виз гаргаж буй байдлаараа хувь нэмэр оруулсан эсэх асуудлыг шалгах парламентын хороо томилох шийдвэрийг сөрөг хүчний хүсэлтийн дагуу Бундестаг 2004 оны 12 дугаар сарын 17-нд гаргасан. Украинаас гаралтай хар тамхины наймаачны хэргийг 2004 оны 2 дугаар сарын 9-нд Кельн хотын шүүхэд шийдвэрлэснээр энэ шалтгааныг гаргаж ирсэн. Гадаад хэргийн яам "ихээхэн алдаатай үйлдлээрээ" хэрэгтэнд боломж олгосон учраас шүүгч ял оноохдоо нөхцөл байдлыг зөөлрүүлж үзэхийг зөвшөөрсөн. Шалгаах Хорооны Хэлэлцээнд Йошка Фишерийн гарын үсэг бүхий 2000 оны 3 дугаар сарын 3-ны тушаал (юны өмнө Фольмерийн тушаал гэж тодорхойлсон) гол анхаарал татаж байсан бөгөөд уг тушаалын дагуу гадаадад Германыг төлөөлөх байгууллагууд жуулчны виз олгож байхаар болж, эрх нь нэмэгдсэн. Зарим тодорхой тохиолдлуудад чөлөөтэй аялан жуулчлах асуудалд эргэлзсэн үед тэрээр шийдвэр гаргах боломжтой болсон. 1995 онд аялан жуулчлахад хөнгөлөлтийг үзүүлэх болсноос хойш ихээхэн нэмэгдсэн Германы виз Зүүн Европын орнуудад 2000 оноос эрс нэмэгдэж, украинчуудын хувьд 1999-2001 онд 297.000 хүртэл бууу хоёр дахин өсчээ. Аялал жуулчлалын компаниудын үйлдэл, хэд хэдэн даатгалын компаниуд хүсэлт гаргагчдын аялалын зорилго, буцаж ирэх хүсэл зэргийг нарийн шалгаж, жуулчлалыг хамгаалах паспортыг олгох явдлыг хүлээн зөвшөөрсөн явдал нь ялангуяа хар тамхины наймаачид жуулчлалын хөнгөлөлтийг буруугаар ашиглах явдал түгэн дэлгэрэхэд гол түлхэцийг үзүүлсэн байна (дээрх хоёр хэргийг Киевт 2001 оны 10 дугаар сар, 2002 оны 6 дугаар саруудад найруулсан). Гадаад Хэргийн яаманд Төрийн сайд асан Лүдгэр Фольмер 2005 оны 4 дүгээр сарын 21-нд Германы Парламентат ёсноо байх гэрчийн анхны мэдүүлэг өгөхдөө (үүнийг телевизээр шууд дамжуулдаг) шалгах хорооны өмнө тэрхүү маргаантай тушаалыг зөв зүйтэй, эрх чөлөөг дэмжсэн, иргэдийн хувьд найрсаг таатай хэмээн хамгаалжээ. Гадаад хэргийн сайд Фишер 4 дүгээр сарын 25-нд энэ нь түүний өөрийн алдаа, түүний яамны алдаа байсан гэдгээ хүлээж, визийн асуудлаар ийнхүү скандал дэлгэж гадаад бодлогод хохирол учруулсанд сөрөг хүчнийг зэмлээд авав. Шүүмжлэлд өртөөд буй визны бодлогын улмаас гэмт хэрэг анхаарал

татахуйц хэмжээгээр өссөн тухай цагдаагийнхан түүнд мэдэгдээгүй хэмээн Дотоод Хэргийн сайд Отто Шили 2005 оны 7 дугаар сарын 16-нд дээрх хорооныхны өмнө онцлон тэмдэглэсэн байна.

Гишүүдийн давхар орлого: ХАХ намын нэртэй улс төрчид болох Херманн-Йозеф Арентц болон Лауренц Мейер нар тогтмол бус давхар орлогоо нуун дарагдуулсны улмаас 2004 оны 12 дугаар сард огцорсны дараахан 2005 оны 1 дүгээр сарын 14-нд ГСДН-ын Бундестагийн гишүүн Яанн-Петер Яанссэн мандатаа буцааж, 1 дүгээр сарын 24-нд Ульрике Флах (ЧАН) албан тушаалаасаа өөрийн хүсэлтээр огцорсон зэрэг хэргүүд шил шилээ даран гарчээ. ФВ-концерны үйлдвэрийн зөвлөлийн гишүүн асан Яанссен хэдийгээр 1994 онд Бундестагийн сонгуульд оролцсоноос хойш тус концернд ажиллаагүй ч компанийн мэдээлснээр 2004 он хүртэл түүний нэр цалингийн жагсаалтанд бичигдсээр ирсэн ажээ.

Парламентад орсныхоо дараагаар үргэлжлүүлэн бүтэн цалингаа авсаар ирсэн ГСДН-ын улс төрчид болох бусад 5 гишүүний нэрсийг ФВ 1 дүгээр сарын 13-нд зарласан. Энэ нэрст ГСДН, Бундестагийн гишүүн Ханс-Юрген Уул, Нийдерсаксоны муж улсын парламентын хоёр гишүүн орж байв. Үүний зэрэгцээ улс төрд орсон ажилтныг цааш үргэлжлүүлэн цалинжуулдаг практикийг 1990 оноос хойш хэрэгжүүлж байсныг дуусгавар болгож буйгаа тухайн компаниас мэдэгдсэн. Үйлдвэрийн зөвлөлийн санхүүгийн ажлын талаар өөр бусад хэргүүд дэгдсэнээр 6 дугаар сарын 30-нд үйлдвэрийн зөвлөлийн дарга, 2005 оны 7 дугаар сарын 8-нд боловсон хүчний асуудал хариуцсан дарга Петер Хартц нар албан тушаалаасаа огцорсон.

Ногоон намын гадаад бодлогын талаар мэдээлэгч ажилтан Лүдгэр Фольмер 2005 оны 2 дугаар сарын 12-нд улс төрийн албан тушаалуудаа (Бундестагийн мандатаас бусад) хүлээлгэн өгөх болсон нэг шалтгаан нь тэрээр Гадаад Хэргийн яаманд төрийн сайд байх үедээ улс төрийн болон мэргэжлийн ажлаа сайн хийсэнгүй гэсэн зэмлэл байв. Фольмер ялангуяа визны хэргийн явцад ихээхэн шахалтанд орсон байна.

Эдгээр хэрэг ба олон нийтийн шүүмжлэлийн нөлөөгөөр Бундестаг, Бундесрат нь 2005 оны 6 дугаар сарын 30-наас 7 дугаар

сарын 8-нд парламентын гишүүдийн цалин хөлсийг олон нийтэд улам нээлттэй болгож өгөх Парламентын гишүүдийн хуулийг баталсан. Бундестагийн гишүүд цаашид давхар ажил, үүргээс авч буй бүх орлогоо нийтэд нээлттэй байлгах ёстой бөгөөд үүнийг ерөнхийлөн хэвлүүлж байхаар болсон. Ямар нэгэн хариу арга хэмжээ авалгүйгээр хандив авахыг хориглосон байна.

Пфалзын хэрэг: Холбооны Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга асан Лүдвиг-Холгер 1990-ээд оны эхэн үед зэвсгийн наймаатай холбогдож, зэвсгийн лообийчин Карлхайнз Шрайбер-аас 873.000 ДМ (нийт 446.000 евро) авсан гэдгээ 2005 оны 6 дугаар сарын 28-нд шүүхийн өмнө хүлээсэн. Гомдол гаргасан намын зүгээс түүний хөрөнгийг 3,8 сая ДМ (1,94 сая евро) гэж мэдүүлсэн бөгөөд тэрээр үүнийг хуучин БНАГУ-ын хувьчлалаас бүрдүүлсэн хүлээн зөвшөөрсөн байна.

Шийдвэрүүд

Хуучин эзэмшигчид болон БНАГУ-ын үеийн шинэ оршин суугчид - шийдвэр: 1945-1949 оны хооронд хуучин Зөвлөлтийн эзэмшлийн бүсэд нийгэмчилсэн хувийн эзэмшлийн газруудыг хуучин эзэд нь буцааж авах эрхгүй болсон. Зөвлөлтийн цэргийн засаг захиргаанаас олон улсын түгээмэл эрх зүйд харшилж, хувийн өмчийг хураасныг буцааж авах эрхтэй гэсэн үндэслэлээр гомдол мэдүүлсэнд Холбооны Үндсэн Хуулийн Цэц 2004 оны 12 дугаар сарын 1-нд татгалзсан хариу өгсөн байна. Шүүх ч мөн үүнд эсрэг хариу өгсөн бөгөөд энэ тохиолдолд нэгдсэний дараахан Герман улс ялагч орнуудтай байгуулсан 2+4 гэрээнд газрыг буцааж олгохоос татгалзана гэсэн ажээ.

1992 оны хуулийн дагуу Газрын шинэчлэл-өв (БНАГУ-ын шинэ оршин суугчид) гэсэн нэрээр хор хохиролгүйгээр газрыг хурааж авах үед 2004 оны 1 дүгээр сарын 22-нд анхан шатны шүүхийн шийдвэрийг эсэргүүцэн Холбооны Засгийн газраас гаргасан гомдлыг Штрассбург дахь хүний эрхийн Европын шүүхийн хянан шалгах хэсэг барагдуулсан байна.

Эрүүдэн шийтгэхээр заналхийлсэн шийдвэр: Цагдаагийн орлогч ерөнхийлөгч Вольфганг Дашнерт 10.800 еврогийн мөнгөн торгууль эс бөгөөс 1 жилийн тэнсэнгийн ял оноох шийдвэрийг Франкфуртын мужийн шүүх 2004 оны 12 дугаар сарын 20-нд гаргасан байна. Дашнер хүүхдийг аврахын тулд барьцаа болон аллагын хэрэгт баривчлагдсан бүлэг бусад шашны хэрэгтэн Якоб фон Метцлерийг эрүү шүүлт тулгахаар заналхийлснээр олон нийтийн дунд хурц маргаан дэгдэхэд хүргэсэн байна.

Маннесманны хэрэг: 2004 оны 7 дугаар сарын 22-нд Дюссельдорфын шүүхээс Маннесманн ХК концернийн удирдлагын хуучин 6 гишүүний хэргийг хэрэгсэхгүй болгосныг эсэргүүцэж, 2005 оны 4 дүгээр сарын 5-нд Холбооны Ерөнхий прокурор Кай Нээм Холбооны Дээд Шүүхт шалгуулах хүсэлтийг тавьсан.

Шашны нийгэмлэгийн шийдвэр: 2005 оны 3 дугаар сарын 24-нд Берлин хотын Захиргааны дээд шүүхээс Еэховагийн гэрчүүдэд олон нийтийн эрх бүхий эвлэлийн статусыг хүлээн зөвшөөрсөн. Ингэснээр тэд энэхүү шашны нийгэмлэгүүдийн нэгэн адил эрх ямбыг төрийн зүгээс эдлүүлэх болсон.

Улс төрийн товчоо-хэрэг шийдвэрлэх явц: БНАГУ-ын хилийн дотор хүний эрхийг зөрчиж байсан явдалд хариуцлага тооцох сүүлийн шүүх ажиллагаа болгож, БНАГУ-ын хоёр шилдэг шүүгч болох Ханс Йоахим Бээме, Зийгфрийд Лоренц нарт Берлины шүүх 2004 оны 8 дугаар сарын 6-нд 15 сарын тэнсэнгийн хорих ялыг оноосон. Хуучин засгийн эрх барьж байсан Германы Нэгдсэн Социалист Намын улс төрийн товчооны уг хоёр гишүүнийг гурван удаагийн аллагад тусалсан хэмээн буруутгасан ажээ. Тэд буудан алах шийдвэр гаргахад оролцоогүй бөгөөд харин шударга бус зүйлд хориг тавих боломжоо ашиглаагүй ажээ.

Капланы хэрэг: Хэдийгээр Холбооны Захиргааны шүүхэд хэргийг дахин хянаж байсан ч үндсэрхэг, туркийн исламчуудын удирдагч Метин Каплан-ыг 2004 оны 10 дугаар сарын 12-нд Турк руу хөөн явуулсан. Ингэх зөвшөөрлийг Кельн хотын захиргааны шүүхээс өгсөн бөгөөд 2005 оны 3 дугаар сарын 17-нд Штуттгартын прокурорын

газраас Каплан толгойлогчтой "Халифатын улс" хэмээх хориотой байгууллагын 33 талархан дэмжигчийн эсрэг гомдол мэдүүлжээ.

Иргэний эрх: Мэдээллийн эрх чөлөөний хууль байгууллагын нууцын зарчмыг захиргааны олон нийтийн зарчмаар сольсон. Иргэн нь Холбооны албан мэдээлэлд хүрэх үндсэн эрхийг эдэлнэ. Тусгай журмын хүрээнд албаны нууц, аюулгүй байдлын сонирхол болон гуравдагч этгээдийн сонирхлыг хамгаална. 2005 оны 6 дугаар сарын 3-нд улаан-ногоон намуудын дийлэнхийн саналаар Бундестаг баталж, 7 дугаар сарын 8-нд Бундесрат хуулийн төслийг зөвшөөрсөн байна.

Аж ахуйн нэгж, төрийн алба

Орон тоог бууруулсан нь: Дэлхийд томд тооцогдох АНУ-ын авто үйлдвэрлэгч Женерал Моторс алдагдалд орсон хэмээн зарлаж, Европт 2 жилийн дотор 12.000 ажлын байрыг цомхотгож, 1 тэрбум еврог хадгалахыг зорьсноор Адам Опел ХК-нийн үйлдвэрлэлийн газруудад 2004 оны 9 дугаар сард ажиллагсад эсэргүүцлээ илэрхийлсэн. Бохумын үйлдвэрийн хамт олон хэдэн хоногийн туршид "зэрлэг" ажил хаялтыг зохион байгуулсан. 2010 хүртэл оршин тогтнох баталгаа болон хамт олны цалин буурах, ажлын цагийг уян хатан зохицуулах асуудлыг багтаасан Ирээдүйн гэрээг 2005 оны 3 дугаар сарын 4-нд үйлдвэрийн удирдлага болон нийт үйлдвэрийн зөвлөл нь байгуулсан байна.

Дөрөв дэх том барилгын концерн болох Аугсбургийн Вальтер Бау ХК 2005 оны 1 дүгээр сарын 2-нд уралдаан зарласан бөгөөд үүнд 9500 ажлын байрыг хамруулсан байна.

Ирэх 2 жилд гадаадад ажиллаж буй ажиллагсдын тоог (65.000) нийт 6.400-аар, дотоодод ажиллагсдын орон тоог (27.300) 2000-аар багасгах төлөвлөгөөтэй буйгаа Германы Банк ХК-ны Удирдах Зөвлөл 12 дугаар сарын эхээр зарласан нь олон нийтийн зэвүү дургүйг хүргэсэн бөгөөд учир нь энэ мэдээг банкны эдийн засгийн байдал гойд сайн үр дүнтэй байх үед гаргасантай холбоотой юм. Банк 2004 онд урьд жилтэй харьцуулахад татварын ашгаа (4,1 тэрбум евро) 50%-иар нэмэгдүүлсэн байна.

Менежерийн цалин: Холбооны намууд 2005 оны 7 дугаар сарын 8-нд зөвшөөрсөнөөр батлагдсан хуулийн дагуу хэрвээ хувьцаа эзэмшигчдийн 75% нь татгалзахгүй бол биржээр дамждаг ХК-уудын удирдлагууд орлогоо нийтэд хэвлэн мэдээлэх үүрэг хүлээсэн. Нийт эдийн засгийн байдал, компанийн байдлыг үл тоомсорлон томоохон компаниудын удирдлагууд толгой дарааллан орлогоо маш эрчимтэй нэмэгдүүлснээс үүдэн олон нийтийн шүүмжлэл гарсныг хууль тогтоогчид хүлээн авсан ажээ. Германы корпорацийн удирдлагын кодексын журам нь үр ашиг багатай гэдэг нь батлагдсаны дараагаар хуулийн хэлэлцэж эхэлсэн.

Төрийн алба: Холбооны Дотоод Хэргийн сайд Отто Шили (ГСДН) 2004 оны 10 дугаар сарын 5-нд албан хаагчдын холбоотой асуудлаар, 10 дугаар сарын эхээр Германы Ферди нийгэмлэгтэй албан хаагчдын эрхийг шинэчлэх асуудлаар санал нэгдсэн. Хөтөлбөрийн гол цөм нь муж улсууд болон коммуны 1,7 сая албан хаагчдын ажлын дүнгээс хамаарч цалин хөлс олгодог болгож өөрчлөхөд оршиж байна. Төрийн албанд ажиллаж буй 2,1 сая албан хаагчдын хувьд 2005 оны 2 дугаар сарын 9-нд холбоо, коммуны хооронд хэлэлцэж тохирсон тарифын шинэчлэлийн үндсэн элементүүдийн нэг нь ажлын үр дүнгээс хамаарч цалин хөлс олгодог болгох явдал юм. Муж улсууд 900.000 ажиллагсдынхаа хувьд дүрэм журмыг хүлээн авсангүй. Гэрээний бусад чухал хэсэгт гэрээг хэрэгжүүлэх дараагийн 3 жилд тарифын цалинг нэмэгдүүлэхээс татгалзах, (жилд нэг удаа 300 еврогийн нэмэлт авна) тусгай төлбөр тооцоог бууруулах, 7 хоногт 39 цаг ажиллах нэгдсэн норм тогтоох, ажлын цагийг уян хатан болгох, цалингийн бүтцийг өөрчлөх зэрэг орж байна.

Холбооны зэвсэгт хүчин

Гадаадад зэвсэгт хүчнээ илгээх: Бундесрат нь сөрөг хүчнийхэн журмыг зөвшөөрөхгүй байсныг үл харгалзан 2005 оны 12 дугаар сарын 3-нд Бундестагийн баталсан Парламентын оролцооны тухай хуулийг 2005 оны 2 дугаар сарын 18-нд зөвшөөрсөн байна. Үүний дагуу цэргээ гадаадад илгээх бүр Бундестагаас зөвшөөрөл авах шаардлагатай бөгөөд хүлээх аргагүй тохиолдолд дараад нь даруй нөхөж зөвшөөрөл авна. Багахан оролцооны асуудлыг

хялбаршуулсан байдлаар шийдвэрлэж байна. Гадаадад буй цэргийнхээ ажиллагааны явцын талаар Засгийн газар Парламентад байнга мэдээлэх ёстой бөгөөд Парламент хэзээ ч энэ ажиллагааг зогсоох эрхтэй юм. Парламент хуулийг гаргаснаар 1994 оны Холбооны Үндсэн Хуулийн Цэцийн шаардлагыг биелүүлж буй юм.

2004 оны 9 дүгээр сарын 24-нд Холбооны Батлан хамгаалахын сайд Петер Штрук тухайн жилийн 3 дугаар сард тун таагүй байдал үүссэн үеэр Косово дахь Холбооны зэвсэгт хүчний оролцоо учир дутагдалтай байгаа талаар Холбооны Бундестагийн өмнө мэдэгдсэн. Энэ нөхцөлд цэргүүдийг хангалттай сайн сургаагүй, зэвсэглээгүй гэсэн дотоодын судалгааны дүн гарсан байна. 2005 оны 6 дугаар сарын 2-нд Бундестаг Косово дахь цэргийнхээ оролцоог нэг жилээр сунгах шийдвэрийг гаргасан (575 зөвшөөрсөн санал, 7 татгалзсан санал). Энэ үед 2600 цэрэг бүхий Германы хэсэг КФОР-ын энхийн цэрэгт хамгийн олон тоотой нь байлаа.

Афганистан дахь ИСАФ-ын үйл ажиллагааны хүрээнд Холбооны зэвсэгт хүчнийг 2000 цэргийн бүрэлдэхүүнтэйгээр оролцуулах явдлыг 2004 оны 9 дүгээр сарын 30-нд дахин нэг жилээр сунгасан. 4 дүгээр сарын сүүлчээр Холбооны Батлан хамгаалахын сайд Штрук Холбооны зэвсэгт хүчний оролцоог тус улсын хойд хэсгийг бүхэлд нь хамруулж нэмэгдүүлэхэд бэлэн буйгаа илэрхийлсэн байна. 2004 оны 6 дугаар сарын 25-нд Кундуст тэсрэх бөмбөгний дэлбэрэлтэнд ертөж Холбооны зэвсэгт хүчний хоёр цэрэг, зургаан афган нас барсан.

НҮБ-ын энхийн үйл ажиллагаанд оролцуулахаар Холбооны зэвсэгт хүчний 75 хүртэлх цэргийг Судан руу илгээх шийдвэрийг Бундестаг 2005 оны 4 дүгээр сарын 22-нд дийлэнх олонхийн саналаар зөвшөөрсөн. Энэ удаад иргэний дайны голомт Дарфур орчмоос гадуур үл зэвсэглэн ажиглах үүрэгтэй бөгөөд энэ нь зургаан сарын хугацаатай.

Зэвсэгт хүчнийг хариуцагч: Бундестагт зэвсэгт хүчнийг хариуцагч Виллфрийд Пеннер (ГСДН) халаагаа өгч буй бөгөөд 2005 оны 3 дугаар сарын 15-нд танилцуулсан сүүлчийн тайландаа тэрээр Холбооны зэвсэгт хүчний гүйцэтгэх үүрэг нь нэмэгдсэн ч

түүний төсөв нь хязгаарлагдаж буйн улмаас Холбооны зэвсэгт хүчин гацаанд орж, ачааллын хязгаарт хүрснийг тогтоосон байна. Холбооны зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнээс түүнд ирүүлсэн гомдлын тоо 2004 онд бага зэрэг өсч, 6154-д хүрсэн байна. Зэвсэгт хүчнийг хариуцагч этгээдийг Бундестаг шинээр сонгох үед 2005 оны 4 дүгээр сарын 14-нд ГСДН-ын гишүүн Райнхольд Роббе өрсөлдөөнт санал хураалтанд ялжээ. Цэргийн дайны албыг өмнө эсэргүүцэж асан түүнийг нэр дэвшүүлсэн нь анхаарал татсан юм.

Зэвсэглэл: Маргаан шуугиан дэгдээсэн олон үндэстний Пуужингийн довтолгооноос хамгаалах систем MEADS-д зориулж 2012 он хүртэл 834 сая еврогийн хувь хөрөнгийг гаргах явдлыг 2005 оны 4 дүгээр сарын 20-нд Төсвийн хороо зөвшөөрсөн байна. Үүний хойно 12 батерейг бүтээх өртгийг 2,85 тэрбум еврогоор тооцсон. Эвслийнхний эрх чөлөөний сонирхол, АНУ-тай харилцах харилцааны сонирхлын талаар удаан зөрчилдсөний эцэст ногооны намынхан энэ төслийг зөвшөөрсөн.

Итгэл үнэмшлийн эрх чөлөө: Итгэл үнэмшлийн улмаас цэрэг тушаалыг биелүүлэхээс татгалзах тухай 2005 оны 6 дугаар сарын 22-ны шийдвэрийг Холбооны захиргааны хэргийн шүүх зөвшөөрсөн. Цэргийн албаны шүүхээс хатуу донгодсоны хариуд нэгэн дэслэгч гомдол гаргасан. Тэрээр итгэл үнэмшлийн улмаас АНУ Иракт дайтахыг шууд бусаар дэмжих явдлыг өөрөөр хэлбэл цэргийн компьютерийн хөтөлбөрт ажиллахаас 2003 оны 4 дүгээр сард татгалзсаны дараа түүнийг ахлагч болгож цолыг бууруулсан байна. Цэрэг дайнаас татгалзах эрхийг үл хүндэтгэсэн хэмээн Үндсэн Хуулийн 4 дүгээр зүйлд тулгуурлаж, Шүүх цэргийн талыг зөвтгөсөн.

Гадаад бодлого

НҮБ-ын шинэчлэлийн хүрээнд Холбооны Засгийн газар НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлд хориг тавих эрх бүхий байнгын суудалтай болохын тулд төрөл бүрийн дипломат ажиллагааг явуулсан. Үүнд АНУ-ын сонирхол зөрчилдөж байсан бөгөөд дотно түншүүдийн

хооронд дахин түр зуур харилцаа хүйтэрсэн. Энэ нөхцөлд Иракт тогтвортой байдлыг бий болгох оролдлого чармайлтад оролцохдоо Герман цэргээ тийш нь явуулалгүйгээр оролцсон байна. Европы Холбооны санхүүгийн төлөвлөгөөний талаар нэгдмэл байдалд хүрч чадаагүй бөгөөд үндэсний сонирхлыг илүүд үзсэнээр Европын бодлого бүтэлгүйтсэн.

Цунамигийн тусламж: Энэтхэгийн далайд газар хөдөлсний дараа 2004 оны 12 дугаар сарын 26-нд Зүүн өмнөд Азийн эрэгт далайн давалгаа цалгин орж ирснээр 6 дугаар сарын эцсийн байдлаар 46 сураггүй бологсдыг оруулан тооцвол Германы нийт 557 иргэн нас барсан. Гамшгийн хэмжээг анхлан баримжаалсны дараа Холбооны зэвсэгт хүчин хээрийн эмнэлэг, эмнэлгийн үйлчилгээг онгоц болон "Берлин" хэмээх усан онгоцоор тус тус үзүүлсэн нь гадаадад үзүүлсэн өнөөг хүртэлх хамгийн том хүмүүнлэгийн тусламжийн оролцоо байлаа. Энэхүү тусламж нь Индонезийн Асээгийн бүс нутагт төвлөрч, 3 дугаар сарын дунд үе хүртэл үргэлжилсэн. Ийнхүү Индонез нь Шриланкын хамт Германы гамшгийн тусламжийг хүртэгч гол улс болсон байна. Холбооны Засгийн газар 2005 оны 1 дүгээр сарын 5-нд 500 сая еврог нийт тусламжинд олгохоор шийдвэрлэснээс 125 сая еврог 2005 онд олгохоор, бусдыг нь Парисын клубын зээлдүүлэгч орны хүрээнд нилээд хэд хэдэн улсын өрийг хүчингүй болгож, дундад хугацаанд сэргээн босгох төсөл гэх мэт бусад арга хэмжээнд зориулна. Мөн ард түмний хандив өнөөг хүртэл тодорхой бус хэмжээнд хүрсэн бөгөөд нийт 60 орчим тусламжийн байгууллагууд 600 сая гаруй еврогийн хандивын мөнгийг хүлээн авчээ.

Нэгдсэн Үндэстний Байгууллага: Гадаад Хэргийн сайд Фишер 2004 оны 9 дүгээр сарын 23-нд Нью-Йорк хотноо Ерөнхий Ассамблейн Чуулган дээр Аюулгүйн Зөвлөлд Герман улс нь эрх бүхий байнгын гишүүн болох эрхтэйг үндэслэн тайлбарласан.

АНУ: Жорж Буш хоёр дахь удаагаа сонгогдох үедээ буюу 2005 оны 1 дүгээр сарын 20-нд олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэхэд бэлэн буйгаа зарласныг Холбооны Засгийн газар илтэд дэмжсэн. Шинэ эхлэлийг хоёр тал харилцааны уур амьсгалыг сайжруулах завшаан болгож ашигласан бөгөөд энэ нь Гадаад Хэргийн сайд

Фишер удахгүй ажлаа хүлээн авах гэж буй ажил хэргийн нөхөр Кондолеза Райс-ын урилгаар 1 дүгээр сарын 25-нд Вашингтонд айлчлах үеэр харагдсан. Аюулгүй байдлын урьдчилан сэргийлэх хүчтэй арга хэмжээг авсны дараа Ерөнхийлөгч Жорж Буш 3 дугаар сарын 23-нд Майнц-д айлчилсан бөгөөд үүнд Майнц, Вийзбадены Дотоод яамдын мэдээгээр 5,2 сая евро зарцуулж, Ираны цөмийн хөтөлбөр болон дэлхийн бодлогын шинэ асуудлаар санал нэгдэж, хамтран ажиллахад бэлэн гэдгээ харуулсан ажээ.

НАТО: Аюулгүй байдлын бодлогын асуудлаар 2005 оны 2 дугаар сарын 12-нд Мюнхенд чуулсан 41-р Бага хурал дээр Батлан хамгаалахын сайд Штрукын уншиж танилцуулсан Холбооны Канцлерын үгэнд НАТО-д шинэчлэлийг уг үндсээр нь хийхийг шаардсан байна.

Европын бодлого: Германы Европт чиглэсэн бодлого нь АНУ ба ОХУ-тай харилцах харилцааны нэгэн адил Францтай саналаа нягт уялдуулахыг чухалчилсан. Энэ нь ЕХ-ны төвшинд улс төрийн маргаан дагуулдаг, сөргөлдөөнтэй, чухал бүх сэдвүүдэд Герман, Францын байр суурь, сонирхлыг цаашид хэрэгжүүлэхийг нотолж өгсөн.

Бундестаг 2005 оны 5 дугаар сарын 12-нд ЕХ-ны Үндсэн хуулийн гэрээг 569 саналаар зөвшөөрсөн бөгөөд үүнд 23 татгалзсан санал байснаас 20 нь ХАХ-ынх, 2 нь түтгэлзсэн санал байв. ГСДН-ЧСН-ын эрх барьж буй Мекленбург-Порпоммерн түтгэлзсэн санал өгснөөс бусдаар бүх Холбооны муж улсуудын саналаар Бундесрат 5 дугаар сарын 27-нд үүнийг зөвшөөрсөн.

Польш: 2005 оны 1 дүгээр сарын 7-нд хоёр талын харилцааг зуучлан холбогч нар үйл ажилгаагаа эхэлсэн бөгөөд Германы талаас Франкфурт/Одер дахь Виадринагийн Их Сургуулийн Ерөнхийлөгч хатагтай Гезине Шван, Польшийн талаас өдгөө Австрид суугаа элчин сайд, хатагтай Ирене Липовикс нарыг 2004 оны 11 дүгээр сарын 4-нд Холбооны Канцлер Шредер болон Ерөнхий сайд Марек Белка нар уулзахдаа тус тус томилсон байна. Энэ завшааныг ашиглан мэргэжилтнүүдийн хамтарсан комиссын үр дүнг танилцуулж, дайны төлбөрийн тухай маргааныг дуусгавар болсон гэж тодорхойлсон.

Турк: Турк ЕХ-нд элсэхэд цааргалах явдал ЕХ-ны улсууд болон Туркт ч мөн өөрт нь өсөн нэмэгдэж буй энэ үед Холбооны Канцлер Шрёдер 5 дугаар сарын 3-нд Анкарад айлчлах үедээ гишүүнээр элсэх төлөв байдлын тухай болон мөн 2005 оны 10 дугаар сарын 3-нд Хэлэлцээг эхлэх гэж буйг онцлон тэмдэглэсэн байна.

Хоёр талын харилцааны зөрчлийг арилгахын тулд 6 дугаар сарын 16-нд Бундестагийн бүх фракцууд санал нэгдэн "европчуудын дурсан санах соёл"-ын үүднээс 1915-1917 оны хооронд Османы Эзэнт улсад арменчуудыг аймаглан устгасныг өөрийн түүхийн нэг хэсэг хэмээн хүлээн зөвшөөрөхийг Туркээс шаардах шийдвэр гаргасан. Үүний зэрэгцээ Парламентын гишүүд 1,5 сая арменчуудыг хэлмэгдүүлсэн энэ үйл ажиллагаанд Герман ч мөн хариуцлагыг хамт үүрэлцэх ёстой гэж үзэж байсан. Ард түмнийг аймаглан устгах гэсэн үгийг Бундестаг шийдвэртээ хэрэглээгүй. Гадаад Хэргийн сайд Абдуллах Гүл уг шийдвэрийг Туркийн төдийгүй Германд амьдарч буй туркчуудын нэр төрд халдсан хэрэг хэмээн шүүмжилсэн ба Анкара дахь Германы элчин сайдыг дуудсан байна.

Ливи: ЕХ 2004 оны 10 дугаар сарын 11-нд Ливийн эсрэг авсан хоригийг цуцалсны дараа Шрёдер 10 дугаар сарын 15-нд хойд Африкийн улсуудад айлчилсан нь Германаас тус улсад зочилсон анхны Канцлер бөгөөд Засгийн газрын тэргүүн болжээ.

Ойн баяр

2005 онд Штайф-тедди бамбарууш 125 настай болсон. Түүний энэ төрсөн өдрийг тохиолдуулан Штайф фирм өөрийн компани байрлах Бренц дэх Гийнгенд чихмэл амьтдын музейг нээсэн. Цүрихын уран барималч Андреас Рамзайерын зураг төслийн дагуу 10 сая еврогийн өртөг бүхий барилга баригдсан. 2002 онд зохиосон дуудлага худалдаанд 1926/1927 оны тедди бамбарууш өнөөг хүртэлх хамгийн өндөр үнэ буюу 140.000 еврод хүрсэн байна. Одоогоос 150 жилийн тэртээ буюу 1855 оны 7 дугаар сарын 1-нд ном хэвлэгч, театрын жүжигчин Эрнст Литфасс өөрийн нэрээр нэрлэсэн сурталчилгааны баганыг нийтэд үзүүлж байжээ. Уг нь түүнийг модоор хийдэг байсан боловч өдгөө ихэвчлэн бетоноор хийх болжээ. Берлин дэх Фраунхофын Институт дотоод орон зайд